



Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар

МОНГОЛ УЛС

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ

2017 оны 6-р сарын 26-н болон 7-р сарын 7-ны өдрүүд

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон
Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны
эцсийн тайлан



Варшав хот
2017 оны 10-р сарын 27-ны өдөр

ГАРЧИГ

I. ХУРААНГУЙ	Error! Bookmark not defined.
II. ТАНИЛЦУУЛГА, ТАЛАРХАЛ	4
III. ОРШИЛ БА УЛС ТӨРИЙН ОРЧИН	5
IV. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН	6
V. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО	7
VI. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА	7
VII. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ	10
VIII. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ	13
IX. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ОРЧИН	14
X. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ	17
XI. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ	20
A. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИН	20
B. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	21
C. ЕАБХАБ/АИХЭГ-ЫН САХ-НЫ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГ	22
XII. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦОО	24
XIII. ИРГЭД БА ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД	25
XIV. ӨРГӨДӨЛ ГӨМДӨЛ	26
XV. СОНГУУЛИЙН ӨДӨР (АНХАН ШАТНЫ САНАЛ ХУРААЛТ)	28
A. САНАЛ АВАХ БОЛОН САНАЛ ТООЛОХ ҮЙЛ ЯВЦ.....	29
B. СОНГУУЛИЙН ДҮНГ НЭГТГЭЖ, ЗАРЛАХ ҮЙЛ ЯВЦ.....	29
XVI. АНХАН ШАТНЫ СОНГУУЛИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ	30
XVII. СОНГУУЛИЙН ӨДӨР (ХОЁР ДАХЬ ШАТНЫ САНАЛ ХУРААЛТ)	31
A. САНАЛ АВАХ БОЛОН САНАЛ ТООЛОХ ҮЙЛ ЯВЦ.....	31
B. СОНГУУЛИЙН ДҮНГ НЭГТГЭЖ, ЗАРЛАХ ҮЙЛ ЯВЦ.....	32
XVIII. СОНГУУЛИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ	33
XIX. ЗӨВЛӨМЖ	34
A. НЭН ТЭРГҮҮНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД.....	34
B. БУСАД ЗӨВЛӨМЖҮҮД.....	35
ХАВСРАЛТ I – Сонгуулийн дүн	38
ХАВСРАЛТ II – Олон улсын сонгуулийг ажиглах хорооны ажиглагчдын нэрийн жагсаалт	40
ЕАБХАБ-ЫН АИХЭГ-ЫН ТУХАЙ	42

МОНГОЛ УЛС
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ
2017 оны 6-р сарын 26 болон 7-р сарын 7-ны өдрүүд

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны тайлан¹

I. ХУРААНГУЙ

Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон 2017 оны 6-р сарын 26-ны өдрийн ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагааг ажиглах урилгын дагуу ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (ЕАБХАБ/АИХЭГ)-аас Сонгууль ажиглах хязгаарлагдмал хороо (САХХ)-г мөн оны 5-р сарын 22-ны өдөр байгуулав. Тус хороо нь ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтын үйл ажиллагааг мөн ажиглав. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ нь ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг, ардчилсан сонгуультай холбогдох олон улсын бусад хэм хэмжээ, түүнчлэн дотоодын хууль тогтоомжууд хэрхэн мөрдөгдөж буйд үнэлгээ хийсэн болно. Зургаадугаар сарын 26-ны өдөр явагдсан анхан шатны сонгуулийг ажиглахад ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-той ЕАБХАБ-ын Парламентын Ассамблей болон Европын парламентын төлөөлөгчид нийлж, олон улсын сонгуулийн ажиглах хороо (ОУСАХ)-г байгуулан ажиллав. Энэхүү ОУСАХ-д хамтран ажилласан байгууллагууд нь Олон улсын сонгуулийг ажиглах зарчмын тухай 2005 оны тунхаглалыг баталсан болно.

ОУСАХ-ноос гаргасан Урьдчилсан тайланд “2017 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн Ерөнхийлөгчийн сонгууль нь өрсөлдөөнтэй, зохион байгуулалт сайтай, сонгуулийн сурталчилгаа богинохон боловч ширүүн болж өнгөрлөө. Эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн байдал боллоо. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацаа сунжирч, шүүхэд шилжүүлсэн хэргүүд шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байгаа нь нэр дэвшигчдийн талаар тодорхойгүй байдал үүсгэв. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн сурталчилгаа өргөн дэлгэр цацагдсан боловч дүн шинжилгээнд суурилсан мэдээллээр дутмаг байлаа. Сонгуулийн байгууллага дунд шатны сонгуулийн хороодын бүрэлдэхүүнийг томилохдоо намын харьяалал харгалзах хандлага байсныг эс тооцвол үр дүнтэй ажилласан” гэж дүгнэжээ.

САХХ-ноос хоёр дахь шатны санал хураалтын дараа гаргасан Урьдчилсан тайланд “Анх удаа явуулсан ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатны санал хураалт нь хууль эрх зүйн тодорхойгүй орчинд болж өнгөрлөө. Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-ны зүгээс тодорхой заавар журам гаргаж, давчуу цаг хугацаанд сонгуулийг амжилттай зохион байгуулсан нь сайшаалтай. Хоёр санал хураалтын хоорондох хугацаа нь төрийн захиргааны байгууллагын албан ёсны үйл ажиллагаа болон улс төрийн сурталчилгаа хоорондын зааг ялгааг алдагдуулсан зөрчлүүдээс гадна сонгогчдын саналыг худалдан авсан гэх мэдэгдлүүдэд будагдаж байв. Хоосон саналын хуудас өгөхийг сонгогчдод уриалсан явдал нь хоёр дахь шатны санал хураалтын содон дүр зураг болов. Сонгууль эмх журамтай явагдаж, сонгуулийн хэсгийн хороодын ажилтнууд санал хураалтыг тогтоосон журмын дагуу явуулсан” гэж дүгнэжээ.

Сонгуулийн тухай хууль тогтоомжинд суурь эрх, эрх чөлөөг баталгаажуулж өгсөн явдал нь ардчилсан сонгууль явуулах хангалттай үндэс суурийг тавьсан байна. Гэвч Сонгуулийн тухай хууль (СТХ) нь сонгуулийн үйл явцын чухал хэсэгт хамаарах зарим зүйл заалтыг хоёрдмол утгатай оруулсан, эсвэл огт орхигдуулсан явдал нь ялангуяа хоёр дахь шатны санал хураалтын талаар эргэлзээтэй байдал үүсгэж байв. Улсын дээд шүүх нь сонгуулийн бүх оролцогч талыг нэгдсэн удирдамжаар хангах СТХ-ийг албан ёсоор тайлбарлах Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлсэнгүй.

¹ Энэхүү тайлангийн зөвхөн англи хэл дээрх хувилбарыг албан ёсны баримт бичиг гэж үзнэ. Монгол хэл дээрх албан бус орчуулгыг авах боломжтой.

СЕХ нь сонгуулийн хоёр удаагийн санал хураалтыг маш сайн зохион байгуулсан бөгөөд хоёр дахь шатны санал хураалттай холбоотой хууль эрх зүйн тодорхойгүй зүйл заалтыг тайлбарлахад ихээхэн хүчин чармайлт гарган ажиллав. Гэвч дунд шатны сонгуулийн хороодын бүрэлдэхүүнийг томилохдоо намын харьяалал харгалзсан гэх хардлага нь сонгуульд оролцогч талуудын сонгуулийн байгууллагад итгэх итгэлийг буруулав.

Энэ удаагийн сонгуульд нийт 1,98 сая орчим сонгогч оролцохоор бүртгэгдсэн. Сонгогчийн нэрийн жагсаалтыг үндэсний иргэний бүртгэл, мэдээллийн санд үндэслэн гаргасан бөгөөд сонгуульд оролцогч талууд нь сонгогчдын бүртгэлийн үнэн зөв, бүх сонгогчийг хамруулсан зэрэгт ерөнхийд нь итгэж байгаагаар илэрхийлэв. Сонгогч сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ цахимаар нэвтэрч, эсвэл биечлэн очиж шалгах боломжтой байв. Хэдийгээр сонгогч санал өгөх газраа солих боломжтой байсан ч сонгогчийн шилжилтийг аймаг дотор хийхийг хориглосон заалт, мөн сонгогчийн эрхийг хязгаарласан зарим заалтууд нь сонгогчийн сонгуулийн эрхийг хязгаарлах эрсдэлд оруулж байлаа.

УИХ-д суудалтай гурван намыг төлөөлсөн гурван нэр дэвшигч энэ удаагийн сонгуульд өрсөлдлөө. Хуулиар бусад нам нэр дэвшүүлэх эрхгүй бөгөөд мөн бие даан нэр дэвшихийг зөвшөөрдөггүй нь сонгогчдын сонголтыг хязгаарлав. Түүнчлэн улс төрийн намууд дотор явагдсан нэр дэвшигчээ тодруулах үйл явцад ил тод байдал дутмаг, олон нийтэд ил болгосон тодорхой шалгуурыг дагаж мөрдсөнгүй.

Сонгуулийн сурталчилгаа өрсөлдөөнтэй явагдаж, иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж чадлаа. Сонгуулийн сурталчилгааны хурал уулзалтуудад нийт орон даяар иргэд олноор оролцож байгаа нь ажиглагдав. Нэр дэвшигчдийн чансааны талаарх яриа хэлэлцүүлгийг зориудаар нэр төрийг нь гутаан доромжлох аястай компанит ажиллагаагаар хиртүүлж байв. Хууль эрх зүйн зохицуулалт тодорхойгүйн улмаас сонгуулийн сурталчилгаа хориотой гэх ойлголт хоёр дахь шатны санал хураалтын өмнө давамгайлж байв. Улмаар улс төрийн намууд “айлаас айлд” хүрэх байдлаар болон нийгмийг сүлжээг ашиглан ухуулга, сурталчилгаа явуулж байлаа. Хоёр дахь шатны санал хураалтын үеэр саналын хуудсыг огт тэмдэглэгээгүй буюу “цагаан хуудас” өгөх уриалга нь дахин сонгууль явуулахыг шахах зорилготой эсэргүүцлээ илэрхийлэх хэлбэрээр гарч ирэв.

Сонгуулийн нийт хугацааны туршид төрийн захиргааны байгууллагын албан ёсны үйл ажиллагаа болон улс төрийн сурталчилгааны хоорондын зааг ялгаа холилдох явдал ажиглагдаж байлаа. Сонгуулийн хоёр дахь шатны санал хураалт болохоос өмнөхөн Засгийн газар улсын төсвөөс хөрөнгө гарган, бэлэн мөнгө шууд тарааж, мөн нийгмийн халамжийн төрөл бүрийн хөтөлбөрийн хүрээнд бусад тэтгэмжүүдийг тавьсан нь төрийн байгууллагын чиг үүргийг буруугаар ашигласан явдал байв. Түүнчлэн нэр дэвшигчдийн нэг нь өөрийн хашиж буй УИХ-ын даргын албан тушаалаа ашиглаж, сонгуулийн сурталчилгаа хийв.

Сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосноор нэр дэвшигчдэд ижил тэгш өрсөлдөх боломжийг бүрдүүлэх зорилготой. Гэсэн хэдий ч сонгуулийн зардлын хязгаарыг мөрдүүлж хянах ёстой Үндэсний аудитын газрын үүрэг үр дүн муутай байсан бөгөөд сонгуулийн санхүүжилтийг зөвхөн сонгуулийн дараа бүрэн тайлагнахаар заажээ. Нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг сонгуулийн дөнгөж өмнөхөн зарласан нь олон нийтэд хяналт шалгалт хийхэд хүндрэлтэй байв. Ийнхүү сонгуулийн зардал, санхүүжилт дээр ил тод байдал ерөнхийдөө дутмаг байсан нь сонгуулийн үйл явцын нэг чухал хэсэгт итгэх итгэлийг сулруулсан.

Хууль эрх зүйн орчин нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулж, өрсөлдөгчдөд хэвлэл мэдээллийн орчинд ижил тэгш эрхийг олгосон. Гэвч хэвлэл мэдээллийн хэрэгслүүд аль нэг талыг баримталж улс төржих, захиалгат төлбөртэй сурталчилгаа явуулах, бие даасан сэтгүүл зүй алдагдах зэрэг дутагдлууд гарч байсан нь сонгогчдод хүргэх мэдээллийг хязгаарлаж байв. ЕАБХАБ/АИХЭГ-ын хэвлэл мэдээллийн мониторингоор Монголын үндэсний олон нийтийн радио телевиз (МҮОНРТ)-ийн редакцийн агуулга засгийн газрыг дэмжсэн өнгө аястай байсан бол, цөөн тооны арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон ургальч яриа хэлэлцүүлгийг хүргэж байсныг харуулжээ.

Нийгэм, улс төр дэх эмэгтэйчүүдийн тэгш оролцооны асуудал нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны үеэр ч, хэвлэл мэдээллээр ч бараг хөндөгдсөнгүй. СЕХ-ны гишүүд болон улс төрийн намууд дотор шийдвэр гаргах албан тушаалууд дээр эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй хэмжээнд байна. Хэдий тийм боловч дунд болон доод шатны сонгуулийн хороодод ажилласан эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс тоогоор илүү, сонгуулийн сурталчилгааны штабууд дээр ч эмэгтэй ажилтнууд давамгайлж байв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хангахад нилээдгүй хүчин чармайлт гаргасан. Мэдээний зарим хөтөлбөр, сонгуулийн сурталчилгаа болон СЕХ-ны сонгогчдын боловсролд зориулсан шторкуудыг дохионы хэлээр цацаж байв. Сонгуулийн байгууллага харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас болон хөгжлийн бусад бэрхшээлтэй иргэдийн санал өгөх нөхцөлийг хөнгөвчлөх хүчин чармайлтуудыг гаргаж байсан. Гэсэн хэдий ч санал авах олон байр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ороход хүндрэлтэй хэвээр байв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөх боломжийг олгосон хэдий ч энэ нь бусад сонгогчдын адил санал авах байранд биечлэн очиж сонгуульд оролцох оролцоог нь дэмжсэнгүй.

Иргэд, олон нийтийн ажиглагчид санал авах өдрөөс өмнөх орчин нөхцөлийг ажиглаж хянахад чухал үүрэгтэй ажиллаж, сонгуультай холбоотой асуудлаар сонгогчдын ойлголт мэдлэгт хувь нэмрээ оруулсан. Иргэд, олон нийтийн ажиглагчид сонгуулийн хоёр санал хураалтын өдөр хоёуланд нь нийслэл хотод цөөн тооны санал авах байрууд дээр ажиглалт хийсэн. Харин нийслэл хотоос гадагш бусад газруудад иргэний нийгмийн байгууллагуудын ажиглалт явуулах боломж хомс байлаа.

Иргэн, хуулийн этгээд нь сонгуулийн үйл явцад хамаарах аливаа шийдвэр, үйл ажиллагааны талаар өргөдөл гомдол гаргах эрхтэй байдаг. Гэвч сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацаа нь сонгуулийн хуанлитай зөрчилдөж байгаа нь хуулиар хамгаалуулах эрхээ цаг хугацааны хувьд төдийгүй үр дүнтэйгээр эдлэх боломжийг хязгаарлаж байна. СЕХ-ны зүгээс сонгуультай холбоотой ирсэн 60 гаруй өргөдөл, гомдлыг шуурхай хянан авч үзсэн ч тэдгээрийг шийдвэрлэх байдал нь тэр бүр нэг мөр байсангүй. Цагдаагийн байгууллага сонгогчдын саналыг худалдаж авах гэсэн олон тооны гомдол хүлээн авснаас гадна нэр дэвшигчдийг хууль бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой гэх хэргүүдийг мөрдөн шалгажээ. Гэвч эл хэргүүдийг хоёр дахь шатны санал хураалтын өмнө шийдвэрлээгүй байсан.

Сонгуулийн санал хууралтын хоёр өдөр улс орон даяр эмх журамтай явагдаж, сонгуулийн хэсгийн хороодын ажилтнууд цаг тулгаж гаргасан дүрэм журмыг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллав. Хоёр дахь шатны санал хураалтын үеэр сонгогчийн саналыг худалдан авахаас урьдчилан сэргийлэх зорилгоор СЕХ-ны зүгээс сонгогчийн бүртгэлийн хуудсыг хурааж авахыг хэсгийн хороодын ажилтнуудад үүрэг болгосон. Хэдийгээр сонгогчдын биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийн мэдээлэл болон санал тоолох төхөөрөмж (СТТ)-нд олон нийт эргэлзэж байсан ч эдгээртэй холбоотой ямар нэгэн ноцтой зөрчил ажиглагдаагүй.

СЕХ нь сонгуулийн хоёр шатны санал хураалт дээр санал авах үйл ажиллагаа дуусмагц шууд урьдчилсан дүнг гаргасан. Гэвч олон нийтэд сонгуулийн дүнг сонгуулийн хэсгийн хороо тус бүрээр задалж мэдээлээгүй нь гаднаас хянах боломжийг буруулсан. Ил тод байдлыг болон иргэдийн мэдээлэл авах эрхийг бүрэн хангахуйц орчин үеийн технологийн шийдэл байсан хэдий ч СЕХ-ны зүгээс хоёр дахь шатны санал хураалтын дүнг гаргахдаа үүнийг ашиглаагүй.

Сонгуулийн дүнг улс төрийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн. Шинээр сонгогдсон ерөнхийлөгч нь сонгуулийн санал хураалтын дүн гарснаас хойш хэдхэн цагийн дараа төдийгүй өргөдөл, гомдол гаргах хуулийн хугацаа дуусгавар болоогүй байхад буюу 7 дугаар сарын 10-ны өдөр тангаргаа өргөв.

Энэхүү тайланд Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжуудыг ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг, ардчилсан сонгуультай холбогдох олон улсын бусад хэм хэмжээнд нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий зөвлөмжүүдийг агуулсан болно. Нэн тэргүүний зөвлөмжүүд дотор сонгуулийн хууль тогтоомжийг эргэж харах хэрэгцээ шаардлага, сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд төрийн албан хаагчдыг томилох шалгуурыг тодорхой тогтоох, бие даан нэр дэвших эрхийг зөвшөөрөх, сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх хуулийн хугацааг сонгуулийн үйл ажиллагааны цаг хугацаатай уялдуулах зэрэг болон бусад зөвлөмжүүдийг багтаасан болно. ЕАБХАБ/АИХЭГ нь сонгуулийн үйл явцыг сайжруулахад болон энэхүү тайлан болон өмнөх тайлангуудад өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын эрх бүхий байгууллагуудад дэмжлэг үзүүлэхэд бэлэн гэдгээ үүгээр илэрхийлж байна.

II. ТАНИЛЦУУЛГА, ТАЛАРХАЛ

Монгол Улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн урилгын дагуу, мөн түүнчлэн 2017 оны 2-р сарын 21-нээс 24-ний өдрүүдэд хийгдсэн Урьдчилсан судалгааны тайланд тусгагдсан зөвлөмжинд үндэслэн ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-г мөн оны 5-р сарын 22-ны өдөр байгуулав. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны тэргүүнээр Элчин сайд Гээрт-Хинрич Аренс (ХБНГУ-ын иргэн) ажилласан бөгөөд 11 хүний бүрэлдэхүүнтэй үндсэн баг Улаанбаатар хотод байрлаж, 20 урт хугацааны ажиглагч (УХА) тодорхой газруудад байршин ажиглав.

Зургаадугаар сарын 26-ны санал авах өдөр ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-той ЕАБХАБ-ын Парламентын Ассамблей (ЕАБХАБ-ын ПА) болон Европын парламент (ЕП)-ын төлөөлөгчид хамтран Олон улсын сонгууль ажиглах хороо (ОУСАХ)-г байгуулав. ЕАБХАБ-ын Дарга-улсын Тусгай зохицуулагч болон ЕАБХАБ-ын Богино хугацааны ажиглагчдийн багийн тэргүүнээр Гийглиемо Пиччи (Итали Улс) ажиллав. ЕАБХАБ-ын ПА-н төлөөлөгчдийг Георгиос Вареманос (Грек Улс), ЕП-ын төлөөлөгчдийг Лайма Луциа Андрикиене (Литва Улс) нар тус тус тэргүүлэн ажиллав. ОУСАХ-ны гишүүдийг ЕАБХАБ-ын гишүүн 30 орноос бүрдүүлсэн бөгөөд үүнд ЕАБХАБ/АИХЭГ-аас илгээсэн нийт 66 ажиглагч, ЕАБХАБ-ын ПА-н төлөөлөгч 22 гишүүн болон Европын парламентын төлөөлөгч 9 гишүүн багтсан юм.

Долдугаар сарын 7-ны хоёр дахь шатны санал авах өдөр ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны гишүүдийг ЕАБХАБ-ын гишүүн 23 орноос бүрдүүлсэн бөгөөд үүнд ЕАБХАБ/АИХЭГ-аас илгээсэн 11 шинжээч Улаанбаатар хотод, 19 урт хугацааны ажиглагч багтсан юм.

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ нь сонгуулийн үйл явцад ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалт, ардчилсан сонгуультай холбоотой олон улсын бусад хэм хэмжээ, түүнчлэн дотоодын хууль тогтоомжууд хэрхэн мөрдөгдөж байгаа талаар үнэлгээ хийсэн болно. Энэхүү нэгдсэн тайланг 2017 оны 6-р сарын 27-ны болон 7 дугаар сарын 8-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион

байгуулсан хэвлэлийн бага хурал дээр мэдээлсэн анхан болон хоёр дахь шатны санал хураалтын дараа гаргасан Урьдчилсан тайлангуудад үндэслэн өргөтгөн боловсруулсан.²

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ нь уг сонгуулийг ажиглах урилгыг ирүүлсэн Монгол Улсын эрх бүхий байгууллагууд, Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ), Гадаад хэргийн яам болон бусад байгууллагуудад дэмжин тусалсанд талархалаа илэрхийлж байна. Түүнчлэн тус хорооны гишүүдтэй өөрсдийн үзэл бодлоо хуваалцсан иргэний нийгмийн байгууллагууд, улс төрийн намууд, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагуудад, мөн хамтран ажилласан олон улсын байгууллагуудын төлөөлөлд талархаж буйгаа илэрхийлж байна.

III. ОРШИЛ БА УЛС ТӨРИЙН ОРЧИН

Монгол Улс нь холимог буюу хагас ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс бөгөөд ерөнхийлөгч болон УИХ нь өргөн хүрээтэй, зарим тохиолдолд хоорондоо давхардсан эрх мэдэлтэй байдаг. УИХ болон ерөнхийлөгчийн бүрэн эрхийг дахин хуваарилах талаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар олон нийтийн дунд болон парламент дээр яригдсан хэлэлцүүлэг нь энэ сонгуулийн нэг содон дүр зураг болов. 1992 онд Үндсэн хууль баталснаас хойшхи хугацаанд Монгол Улс нь УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийг тус тус 7 удаа явуулсан бөгөөд ингэхдээ төрийн эрхийг олонхи болон цөөнхийн улс төрийн хүчнүүд ээлжлэн барьж байжээ.

Энэ удаагийн ерөнхийлөгчийн сонгууль нь 2016 оны 6-р сарын 29-ний өдөр болсон УИХ-ын сонгууль болон 2016 оны 6-р, 10-р сард тус тус болсон орон нутгийн хурлын сонгуулийн дараа болов. 2016 оны сонгуулийн мөчлөгөөр Монгол ардын нам (МАН) парламентын 76-н суудлын 65-ыг авч, улс төрийн давамгайл байдалд очсон төдийгүй ихэнх аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд олонхи болсон. Нийт 21 аймгийн засаг даргын суудлын 20 нь МАН-ынх. Ардчилсан нам (АН) УИХ-д 9 суудалтай бөгөөд намын бүлэг байгуулсан. Монгол ардын хувьсгалт нам (МАХН) нэг суудалтай.³ Хэдийгээр ерөнхийлөгчид нэр дэвшигчийг улс төрийн намаас дэвшүүлдэг ч ерөнхийлөгч тангаргаа өргөмөгц улс төрийн хүчний хаярьяллаас татгалздаг.

Энэ удаагийн сонгууль нь эдийн засгийн хямрал үргэлжилж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт доройтон, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, төгрөгийн ханш суларч, ажилгүйдэл ихэссэн нөхцөл байдалд явагдав. Монгол Улс нь энэ оны хоёрдугаар сард Олон улсын валютын сан болон бусад зээлдүүлэгчдээс тусламж авах гэрээг байгуулсан ба ингэснээр шууд төлбөрийн чадваргүй болох эрсдэлээ бууруулж, засгийн газар нийгмийн хамгааллын гол хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэх боломжтой болсон билээ. Эдийн засаг удааширч, мөн эдийн засгийн хувьд улам бүр БНХАУ-аас хамааралтай болж байгаа нь популист үзэл санааг өөгшүүлж, сонгуулиас өмнө тогтворгүй орчин нөхцөл үүсэхэд нөлөөлж байлаа.

Нэр дэвшүүлэх эцсийн хугацаа буюу 5-р сарын 6-ны өдрөөс өмнө УИХ-д суудалтай гурван нам бүгд нэр дэвшигчээ шалгаруулах дотоод сунгааг хийсэн. АН нь сунгааг улс даяар, зургаан нэр дэвшигчтэй, эхний шатыг хаалттай хийж, 5-р сарын 6-ны өдөр Үндэсний их хурлаараа нэр дэвшигчээ албан ёсоор баталсан. МАН нь 5-р сарын 3-нд Намын бүгд хурлаа хийж, хоёр нэр дэвшигчийн нэрийг хэлэлцсэнээр нэр дэвшигчээ тодруулжээ. МАХН нь намынхаа даргыг нэр дэвшүүлсэн бөгөөд СЕХ түүнийг бүртгэхээс татгалзсаны дараа тус нам хуульд заасан хугацаанд багтаан, өөр нэр дэвшигчийг нөхөн дэвшүүлсэн болно. Улс төрийн намуудын явуулсан нэр дэвшигчээ шалгаруулах дотоод сунгаанууд тэр бүр сайтар тодорхойлсон, ил тод шалгуурын

² ЕАБХАБ/АИХЭГ-аас Монгол Улсын талаар гаргасан өмнөх бүх тайлантай танилцана уу.

³ УИХ-д нэг бие даагч гишүүн байгаа.

дагуу явагдаагүй нь улс төрд итгэх сонгогчдын итгэлийг буруулж, улмаар саналаа өгөхөөс түдгэлзсэнээр ирцэд нөлөөлөх магадлалыг нэмэгдүүлж байлаа.⁴

IV. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Сонгуулийн хууль эрх зүйн орчин нь 1992 оны Үндсэн хууль, 2015 оны Сонгуулийн тухай хууль (СТХ), 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (СТБТХ), Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль (САСТХ) зэргээс үндсэндээ бүрдэж байна.⁵ Суурь хууль тогтоомж дээр нэмэгдээд Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-ноос гаргаж буй дүрэм журмууд мөн дагалдаж байна.

Гэвч уг хууль тогтоомжоор шаардлагатай гэж үзсэн зохицуулалтаа батлах, ялангуяа СТХ-тай холбогдох СЕХ-ны бүрэн эрхийг хязгаарласан байгаа нь сонгуулийн хууль тогтоомжийн уялдаа холбоотой, тууштай хэрэгжилтийг баталгаажуулах арга хэрэгсэлгүй болгож байна.

Сонгуулийн байгууллагын тогтолцооны уялдаа холбоог баталгаажуулах, мөн хууль тогтоомжийг тууштай хэрэгжүүлэхэд сонгуулийн хууль тогтоомжид тодотгон нэмэх шаардлагатай гэж үзсэн зохицуулалт (дүрэм, журам)-ыг батлах бүрэн эрхийг СЕХ-нд олгохоор холбогдох хуулийг дахин хянан авч үзэж болох юм.

Сонгуулийн тухай хууль тогтоомж нь ерөнхийдөө ардчилсан сонгууль явуулах хангалттай үндэс суурийг тавьсан. Гэвч СТХ дахь сонгуулийн үйл явцын чухал хэсэгт хамаарах зарим зүйл заалт хоёрдмол утга агуулж, хоорондоо зөрчилдөж буй хуулийн хийдлүүд ажиглагдав. Жишээ нь, олон нийтийн санал асуулгыг хэвлэн нийтлэх, хэвлэл мэдээллийн төлбөртэй сурталчилгаа явуулах, байгууллага хоорондын ажил үүрэг давхцах, сонгуулийн санал хураалтын дараа нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах зүйл заалт болон дахин сонгууль зарлах зэргийг дурдаж болно. Үүний сацуу, СТХ-нд ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтыг зохицуулсан тодорхой зүйл заалт байсангүй. Уг хуулинд сонгогчийн нэрийн жагсаалтын тухай, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлт гаргах, ажиглагч бүртгэх, нэн ялагуяа хоёр санал хураалтын хооронд сонгуулийн сурталчилгаа явуулах асуудал дээр ямар нэгэн зохицуулалт алга байна.

Сонгуулийн тухай хууль тогтоомжинд байгаа хоёрдмол утга агуулсан, хоорондоо зөрчилдөж буй зүйл заалтыг дахин хянан авч үзэж, ялангуяа ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтыг зохицуулсан нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй.

СТБТХ-иар СЕХ нь сонгуулийн хууль тогтоомжийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Дээд шүүхэд оруулах эрхтэй. Гэвч 2012 оноос хойш Дээд шүүх нь албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхээ хэрэгжүүлэхээ больсон.⁶ Хоёр дахь санал хураалтын өмнөх хууль эрх зүйн эргэлзээтэй нөхцөл байдал нь сонгуульд оролцогч талуудыг тодорхой удирдамжаар хангах СТХ-ийг хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг гаргах шаардлага байгааг харуулсан.⁷

⁴ ЕАБХАБ/АИХЭГ-ын болон Хуулиар ардчиллыг тогтоох европын комисс (Венецийн комисс)-ын 2011 оны “Улс төрийн намын зохицуулалтын тухай удирдамж”-ийн 113 дахь хэсэгт “нэр дэвшигчийг ил тод шалгуурын дагуу шалгаруулна” гэж заасныг үзнэ үү.

⁵ Үүнд 2005 оны Улс төрийн намын тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хуулийн зүйл заалтууд мөн орно.

⁶ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд мэдээлэхдээ хэрэв УИХ-аас Шүүхийн тухай хуульд дээд шүүхийн эрх мэдлийг тодорхойлсон шинэ зохицуулалт оруулж өгөхгүй бол хууль тогтоомжийн талаар албан ёсны тайлбар гаргах боломжгүй гэв.

⁷ Хоёр дахь санал хураалтын өмнө сонгуулийн сурталчилгаа явуулах нь хориотой гэдэг дээр эрх бүхий байгууллагууд, улс төрийн намууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд санал нэгтэй байв. Гэвч эдгээр институциуд бүгд СТХ-ийн өөр өөр зүйл заалтыг баримтлан тайлбар хийж байлаа.

Дээд шүүх нь Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ эргэн хэрэгжүүлж, СЕХ-ны хүсэлтээр холбогдох хууль тогтоомжийн талаар албан ёсны тайлбарыг гаргах нь зүйтэй.

2015 оны СТХ-д сонгуулийн тухай хэд хэдэн хуулийг нэгтгэсэн бөгөөд 2016 оны УИХ-ын сонгуулийн өмнө хоёр ч удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. СТХ-нд сонгуулийн хууль эрх зүйн орчинтой холбоотой ЕАБХАБ/АИХЭГ-аас өгсөн өмнөх зөвлөмжүүдийн заримыг тусгасан, тухайлбал нэр төрийг гутаахад ял шийтгэл ноогдуулах тухай эрүүгийн хариуцлага ноогдуулах заалтуудыг хүчингүй болгох, сонгуулийн хороод болон шүүх байгууллага хоорондын давхацсан зохицуулалтуудыг арилгахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан байна. Гэсэн хэдий ч нилээд эртнээс өгсөн тэгш эрхийг хангах болон сонгуультай холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай зөвлөмжүүдийг тусгалгүй орхигдуулсан болно.⁸

V. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Ерөнхийлөгч нь улсын хэмжээнд сонгуулийн нэг тойргоос олонхийн буюу мажоритар тогтолцоо бүхий хоёр шаттай сонгуулиар шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгогдоно. Хэрэв сонгуульд нэр дэвшигчдийн хэн нь ч анхан шатны сонгуулийн дүнгээр олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүнийг анхны санал авснаас хойш 14 хоногийн дотор хоёр дахь санал хураалтад оруулна. Нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол дахин сонгуулийг товлон зарлана.

Хэрэв улсын хэмжээнд сонгуулийн ирц 50 хувиас доош гарвал нэг долоо хоногийн дотор нэмэлт санал хураалт явуулна. Нэмэлт санал хураалтад эхний санал хураалтад оролцоогүй, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч оролцож саналаа өгнө. Нэмэлт санал хураалтыг зөвхөн ирц хүрэлцээгүй (50 хувь) сонгуулийн хэсгүүд дээр явуулна. Нэмэлт санал хураалтаар өгсөн саналын тоог эхний санал хураалтын тоон дээр нэмнэ. Ийнхүү зарим сонгогчдод нэмэлт санал хураалтанд эрх олгосон хэрнээ сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын 50 буюу түүнээс дээш хувь нь оролцсон гэх үндэслэлээр сонгуульд оролцох эрхтэй сонгогчдын нэмэлт санал хураалтад оролцох эрхийг хасч буй явдал нь оршин суугаа газраар ялгаварлан гадуурхахгүй байх болон тэгш сонгох эрхийг зөрчиж, мөн олон улсын хэм хэмжээтэй зөрчилдөж байна. Түүнчлэн нэмэлт санал хураалтаас өмнө сонгуулийн дүнг урьдчилан мэдэх эрсдэлийг дагуулна.

Нэмэлт санал хураалттай холбоотой хууль эрх зүйн болон зохион байгуулалтын асуудал гарах магадлал өндөртэйг харгалзан дээрх зохицуулалтыг бүхэлд нь халах нь зүйтэй. Үргэлжлүүлэн хэрэгжүүлэх аваас СТХ-ийн нэмэлт санал хураалтын тухай зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, тэгш сонгох эрхийг баталгаажуулах нь зохистой.

VI. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Сонгуулийн төв байгууллагын бүтэц нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн зохион байгуулалтад тохирсон. Ерөнхийлөгчийн сонгуулийг үндэсний хэмжээнд СЕХ зохион байгуулдаг бөгөөд тус хороо нь есөн гишүүний бүрэлдэхүүн (нэг гишүүн нь эмэгтэй)-тэй, гишүүд нь зургаан жилийн хугацаатайгаар томилогддог байнгын ажиллагаатай байгууллага юм.

Аймаг бүрт болон Улаанбаатар хотод байнгын бус ажиллагаатай нийт 22 Аймаг нийслэлийн сонгуулийн хороо (АНСХ), сум болон дүүрэгт 339 Сум дүүргийн сонгуулийн хороо (СДСХ) зохион байгуулагдсан. Сонгуулийн санал хураах өдөр 1983 сонгуулийн хэсгийн хороо (СХХ) санал авах, тоолох ажлыг явуулсан. Доод шатны сонгуулийн хороодыг 4 дүгээр сараас 6 дугаар сарын хооронд байгуулсан ба эдгээр хороодын бүрэлдэхүүний дийлэнхийг эмэгтэйчүүд

⁸

Сонгогчийн бүртгэл болон Нэр дэвшигчийн бүртгэл хэсэгтэй тус тус танилцана уу.

бүрдүүлж байлаа.⁹ СЕХ-ноос боловсруулсан хөтөлбөрийн дагуу бүх шатны сонгуулийн хороодод сургалтууд цаг хугацаандаа тогтмол зохион байгуулагджээ. Хоёр санал хураалтын хооронд доод шатны сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй.

СЕХ нь ээлжит сонгуулийг зохион байгуулах цаг хугацааны хуваарь болон хуульд заасан чухал хугацаанд олон үүрэг даалгавруудыг хийж гүйцэтгэлээ.¹⁰ Сонгуулийн байгууллага бүхэлдээ долоо гаруйхан хоногт багтаан хоёр дахь шатны санал хураалтыг зохион байгуулах сорилттой тулгарсан. Энэ нь ийм тохиолдлыг зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт бүдэг, мөн анх удаагаа ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатны санал хураалт тохиосон зэргээс болоод бүр ч хүндрэлтэй байлаа.¹¹ Энэ нь ЕАБХАБ/АИХЭГ-ийн САХХ-нд сонгогчийн нэрийн жагсаалт, сонгогчдод сонгуульд оролцох урилгыг боловсруулах тухай болон сонгуультай холбоотой бусад асуудлаар дунд болон доод шатны сонгуулийн хороодоос өгч байсан янз бүрийн тайлбараас ажиглагдаж байлаа. СЕХ-ны зүгээс 6 дугаар сарын 30-ны өдөр сонгууль зохион байгуулахад нэн хэрэгцээтэй байсан заавар журам батлан, сонгуулийн хороодод хүргүүлсэн. Уг журам нь зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагар санал авах, сонгууль ажиглагчийн бүртгэл, сонгогчийн боловсрол болон СХХ-ын бүрэлдэхүүнд олгох мөнгөн урамшуулал зэргийг зохицуулжээ. Түүнчлэн хоёр шатны санал хураалтын хооронд төвийн бүсийн ихэнх нутгаар эрчим хүч тасалдсан нь сонгуулийг зохион байгуулахад хүндрэл учруулж байлаа.

Хууль тогтоомжийн хүрээнд сонгуулийн байгууллага нь намын харьяалал огт харгалздаггүй, мерит зарчимд суурилсан байгууллага бөгөөд бүх шатны хороодод ажиллах гишүүдийг сургаж бэлтгэгдсэн, мэргэшсэн төрийн албан хаагчдаас сонгон шалгаруулна гэж заажээ. Гэвч энэхүү сонгон шалгаруулах явцыг зохицуулах тусгай журам байхгүйн улмаас хороодын гишүүдийг харьяа орон нутгийн иргэдийн хурлаас бэлтгэн гаргасан төрийн албан хаагчдын жагсаалтыг үндэслэн томилсон байна. Иймээс хороод нь иргэдийн хурал дахь эрх мэдлийн хуваарилалтыг харгалзах хандлагатай байв. 2016 оны УИХ-ны сонгуультай харьцуулахад энэ удаагийн сонгуулийн хороодын бүтэц бүрэлдэхүүнд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан нь ажиглагдав.¹² ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны уулзаж ярилцсан хүмүүс энэ өөрчлөлтүүдийг 2016 оны УИХ-ын сонгуулийн мөчлөгийн дараа орон нутгийн иргэдийн хурлуудад гарсан эрх мэдлийн шилжилттэй холбоотой гэж байв. Энэ байдал нь уг сонгуулийг зохион байгуулахад нөлөөлөөгүй мэт боловч сонгуулийн хороодын томилгоонд намын харьяалал харгалзсан байж болохыг харуулж байна.

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны уулзаж ярилцсан хүмүүс АНСХ болон СДСХ-ын үйл ажиллагаа болон гаргасан шийдвэрүүд нь ихэнхдээ улс төржсөн өнгө аястай байсан гэж байв. Ийм ойлголт нь сонгуулийн хороодын удирдлагууд улс төрийн албан тушаалтнуудын шууд удирдлага дор ажиллаж байгаагаас харагдаж, сонгуулийн байгууллагад итгэх итгэлийг алдагдуулж байлаа. Нийт 22 АНСХ-ны 21-ийг нь аймгийн ЗДТГ-ын дарга (8), ЗДТГ-ын хэлтсийн дарга (9), аймгийн

⁹ АНСХ-ын бүрэлдэхүүний 51 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байв. СДХС, СХХ-ын бүрэлдэхүүний хүйсийн задаргаатай өгөгдөхүүн тараагдаагүй хэдий ч ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчид очсон хороодын бүрэлдэхүүнд эмэгтэйчүүд ойролцоо хувийг эзэлж байгааг ажиглажээ.

¹⁰ Үүнд доод шатны сонгуулийн хороодын байгуулах, нэр дэвшигчдийг бүртгэх, саналын хуудсыг хэвлэх, өргөдөл, гомдол шийдвэрлэх, сонгуулийн дүн гаргах зэрэг ажлууд байлаа.

¹¹ Нэн ялангуяа 7 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд гадаад улсад байгаа иргэдийн хоёр дахь санал хураалтыг зохион байгуулахад маш богино хугацаанд иргэдэд мэдээлэл хүргэх болон 30 гаруй улсад байгаа 42 дипломат төлөөлөгчийн газарт саналын хуудас хугацаанд нь амжиж хүргэх зэрэг томоохон сорилттой тулгарсан.

¹² 2016 оны УИХ-ын сонгуулиас АНСХ-дын гишүүдийн 76 хувь нь өөрчлөгджээ. Зөвхөн гурван АНСХ-ны дарга л солигдоогүй байв. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчдын очсон СДСХ-дод халаа сэлгээ харьцангуй бага хийгдсэн боловч бас л мэдэгдэхүйц байв. Харин СХХ-ын түвшинд мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдсангүй.

ИТХТ-ийн нарийн бичгийн дарга (4) нар даргалжээ. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд үүнтэй төстэй дүр зураг СДСХ-дын гишүүдийг томилоход ажиглагдав.

Сонгууль зохион байгуулах байгууллагын үйл ажиллагааг хардах хардлагыг бууруулахын тулд сонгуулийн хороодын доод шатны бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах шалгуурыг ил тод, тодорхой болгох нь зүйтэй.

СТХ болон СЕХ-ны дүрэм журамд сонгуулийн хороодын хуралдаан, хэлэлцэх асуудлуудыг олон нийтэд зарлан мэдээлж байх ёстой гэж заасан байдаг. Хуралдаанууд нь нээлттэй ил тод байж, хурлын тэмдэглэл зэргийг хөтөлж, аудио бичлэг хийгдэх ёстой. Анхан шатны санал хураалтын үеэр СЕХ нь хуралдаанаар хэлэлцсэн асуудлууд болон шийдвэрүүдээ цахим хэлбэрээр нийтэлж байв. Харин доод шатны хороод дээр болсон хурлуудыг ихэнхдээ олон нийтэд мэдээлэлгүй, хэлэлцэх асуудлуудыг урьдчилан мэдэгдэлгүйгээр хийж, мөн хурлаас гарсан шийдвэрийн үр дүнг тэр бүр олж тодорхойлох боломжгүй байлаа. Зарим АНСХ болон СДСХ-д мэдээлэхдээ, хуралдаанууд нь олон нийтэд дандаа нээлттэй байдаггүй гэж байсан бол, зарим нь хэлэлцэж буй асуудлууд нь хамааралтай тохиолдолд л улс төрийн намуудыг урьж оролцуулдаг гэж ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд тайлбарлаж байлаа. Тиймээс хууль эрх зүйн орчноор тогтоож өгсөн сонгуулийн байгууллагын ил тод байдал ямар нэг хэмжээнд алдагдсан байна. Гэвч хэд хэдэн АНСХ ил тод байдлаа сайжруулахын тулд нийгмийн сүлжээг идэвхтэйгээр ашиглаж байсан нь сайшаалтай.

Сонгуулийн хоёр санал хураалтын хоорондох хугацаанд СЕХ нь хуралдаан зарласнаа тэр бүр урьдчилан мэдээлэхгүй, тухайлбал хоёр дахь санал хураалтын өдрийг товлосон шийдвэрийг гаргасан хуралдааны талаар мэдээлэл байсангүй. Мөн хуралдаанаас гарсан шийдвэрүүд болон бусад чухал мэдээлэл цаг тухайдаа нийтлэгдэхгүй хойшлогдож байв. Сонгуулийн дүн болон хоёр дахь шатны санал хураалтын талаар мэдэх гэсэн сонирхол нэмэгдэж байсан цаг үед мэдээлэл дутмаг, ил тод байдал буурсан нь харамсалтай. Сайшаалтай нь, СЕХ нь сонгуулийн хоёр санал хураалтын хооронд хэвлэлийн бага хурал товлож, анхан шатны санал хураалтын урьдчилсан дүн хоцорч ирсэн талаар тайлбар хийжээ. Доод шатны хороодын тухайд цөөн тооны хурал хийснээс ихэнхэд нь хоёр дахь шатны санал хураалтын зохион байгуулалтын асуудлыг хэлэлцжээ.

СЕХ болон доод шатны сонгуулийн хороод нь хуралдаанаа тогтмол, нээлттэй ил тод зарчим баримтлан, олон нийтэд урьдчилан зарлан мэдээлж, хийж занших нь зүйтэй. Хурлаар хэлэлцэх асуудал, хурлын тэмдэглэл болон гаргасан шийдвэрүүдийг нэн даруй олон нийтэд мэдээлж байх нь зохистой.

СЕХ сонгогчдод сонгуулийн талаар мэдлэг мэдээлэл өгөх нэлээд хэдэн арга хэмжээг хийж хэрэгжүүлсэн. Иргэдийн сонгох эрх, сонгуульд санал өгөх үйл явц зэргийг тайлбарласан гарын авлагыг орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад байрлаж буй мэдээллийн төвүүдэд хүргүүлж, сонгуулийн анхан шатны санал хураалтаас хэдэн долоо хоногийн өмнө олон нийтэд зориулсан мэдээллийг үндэсний радио, телевизээр нэвтрүүлсэн.¹³ Хэдийгээр эдгээр мэдээллийн шторкууд нь сонгуульд санал өгөх үйл явц, сонгуульд оролцох нь яагаад чухал зэргийг тайлбарлаж байсан ч тайлбарлаагүй орхигдуулсан зарим журмын дотор саналын хуудасны нууцлалын хавтас хэрэглэх зааварчилгаа оржээ.¹⁴ Хоёр санал хураалтын хоорондох хугацаанд СЕХ-ны зүгээс хоёр дахь санал хураалтын товын тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн

¹³ СЕХ нь сонгогчдын сонгуулийн боловсролд зориулан 5 дүрс бичлэг болон сонгуульд оролцохыг тайлбарласан хэд хэдэн шторк бэлтгэн гаргажээ.

¹⁴ Сонгогчдын боловсролд зориулсан СЕХ-ны сурталчилгаа нь нийслэл хотод санал өгсөн сонгогчдын хуруун дээр тусгай тэмдэглэгээ тавих, санал хураалт дуусны дараа харьяа СХХ-ноос 50 хувийг санамсаргүй аргаар сонгож техникийн толлого хийх зэрэг хэд хэдэн чухал асуудлыг тайлбарлаагүй орхигдуулжээ. Үүний сацуу сонгогчид сонгуулийн ирц болон босгын талаарх ойлголт дээр будилж байсан ба эдгээрийн сонгуулийн сурталчилгаанд ер тусгаагүй байжээ.

хэрэгслээр нэвтрүүлсэн. АНСХ-д мөн үүнтэй ижил төстэй сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийг орон нутгийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулсан байсан. Гэвч сонгуулийн төсөв хүрэлцээгүй гэх тайлбараар хоёр дахь шатны санал хураалтын үеэр ихэнх нь сонгогчдын боловсролд зориулсан дээрх мэдээллийг дамжуулаагүй. Анхан шатны санал хураалтын өмнө СДСХ болон СХХ-д санал өгөх цаг, санал авах байрны байршлын талаарх мэдэгдлийг сонгогчдын гэрт хүргүүлж байжээ. Зарим сонгуулийн хороод хоёр дахь шатны санал хураалтын өмнө мөн сонгогчдод шууд хандсан уриалга гаргаж байлаа. Энэ мэт хүчин чармайлтууд нь сонгогчдод энэ сонгуультай холбоотой мэдлэг мэдээллийг өгч, сонгуульд оролцож саналаа өгөхөд нь тус дөхөм болсон.

СЕХ-ны зүгээс сонгуулийн шинэ техник технологийг ашиглах болон сонгуулийн дүрэм, журмыг тайлбарлаж, олон нийтэд ойлгуулах зэрэг сонгогчдод нэмэлт мэдээлэл олгох ажлууд хийх нь зүйтэй.

Энэ удаагийн сонгууль нь Монгол Улсын хувьд санал тоолох төхөөрөмж (СТТ) ашиглан явуулж буй зургаа дахь сонгууль юм. Хэдийгээр улс төрийн намууд СТТ-ийн үнэн зөвд эргэлзсэн мэдэгдэл хийж байсан ч ерөнхийдөө санал тоолох төхөөрөмжийн үнэн зөвд олон нийт итгэлтэй байлаа. Сайшаалтай нь, СЕХ төхөөрөмжийн ажиллагааг шалгах шалгалтыг намууд болон иргэд олон нийтийн ажиглагчдыг байлцуулан хийсэн. Улс төрийн нам бүрээс томилогдсон ажиглагчид ч, мөн иргэний нийгмийн байгууллагын ажиглагчид ч өөрсдөө бие даан шалгах боломжтой байсан. Энэхүү шалгалтын үр дүн нь уг төхөөрөмжийн үнэн зөв, аюулгүй ажиллаж байгааг олон нийтэд батлан харуулсан явдал болсон. СТТ-нд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор СЕХ болон иргэд, олон нийтийн ажиглагчдын зүгээс төхөөрөмжийн ажиллагааг шалгасан шалгалтын талаар болон төхөөрөмжийн ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгсөн. СЕХ-нд төхөөрөмжийн програмын эх кодыг хянаж үзэх хүсэлт аль нэг улс төрийн нам болон иргэний нийгмийн байгууллагын зүгээс ирээгүй гэж мэдээлсэн. Техник хангамж болон програм хангамжийн хараат бус баталгаажуулалтыг хийх шаардлагатай гэж хуулинд заагаагүйгээс гадна сонгуульд оролцогч талуудаас ийм хүсэлт ч ирээгүй ажээ.¹⁵

Санал өгөх цахим системд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд төхөөрөмжийн программын эх кодыг гуравдагч этгээдээр хараат бус баталгаажуулалт хийлгэх нь зүйтэй. Ийнхүү хийсэн хараат бус шалгалтын дүнг олон нийтэд нээлттэй байлгах нь зохистой.

Хоёр дахь шатны санал хураалтын өмнө СТТ-нд шинэ саналын хуудасны мэдээлэлд нийцүүлэн программын тохируулгыг СЕХ болон аймгийн төвүүд дээр хийжээ. Мөн СЕХ-ны зүгээс СХХ-дод СТТ-ийг унтрааж, санал хураалтын үр дүнгийн мэдээллийг дамжуулах талаар нэмэлт чиглэл хүргүүлжээ. Сонгуулийн анх шатны санал хураалтын үр дүнгийн мэдээллийг дамжуулахад хэд хэдэн саатал гарсантай холбогдуулан СЕХ нь сонгуулийн хороод болон орон нутгийн удирдлагуудад сонгуулийн санал хураалтын үр дүнг дамжуулахад шаардлагатай тохиолдолд төрийн сангийн сүлжээг ашиглах зааварчилгааг мөн хүргүүлжээ.

VII. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

Арван найман насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай бүх иргэн санал өгөх эрхтэй ч, харин шүүхээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон болон гэмт хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж буй бүх этгээд санал өгөх эрхгүй байдаг. Ингэж бүхэлд нь хязгаарласан явдал нь

¹⁵ Европын Зөвлөл (ЕЗ)-ийн Санал өгөх цахим системээр сонгууль явуулахад баримтлах хууль эрх зүй, үйл ажиллагааны болон техникийн стандартын тухай зөвлөмж (2017)-ийн 5-т “Санал өгөх цахим системээр сонгууль явуулахдаа бүх гишүүн орон ил тод зарчмыг мөрдөнө” гэжээ.

ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй нийцэхгүй байна.¹⁶

Хорих ял эдэлж буй этгээдийн санал өгөх эрхийг хязгаарлахдаа үйлдсэн гэмт хэргийн ангиллаас хамааран хязгаарлах нь зүйтэй. Мөн олон улсын өмнө хүлээсэн үүрэгт нийцүүлэн эрх зүйн чадамжгүй гэх сэтгэцийн болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх эрхийг нь хязгаарласан заалтыг эргэн харж, санал өгөх эрхээ эдлэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох нь зүйтэй.

Сонгогчийн нэрийн жагсаалтыг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар (ОӨУБЕГ)-ын үндэсний иргэний бүртгэл, мэдээллийн санд үндэслэн үйлддэг. Үндэсний иргэний бүртгэлийн сан нь иргэний бүртгэлийн мэдээлэл болон биометрийн мэдээллэлд тулгуурлан сонгогчийг бүртгэдэг. Сонгогч сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн цахим санд нэвтэрч шалгах боломжтой байв. Тавдугаар сарын эхэн гэхэд ОӨУБЕГ-т холбогдох төрийн байгууллагуудаас сонгуулийн насны иргэдийн мэдээллийг хүргүүлснээр сонгогчдын нэрийн жагсаалтын бүртгэлээс заримыг нь хасаж, нэмж, шилжүүлж, “түр хасав” гэсэн нэмэлт тэмдэглэгээг сонгогчдын жагсаалтад оруулжээ. ОӨУБЕГ нь шинэчлэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг АНСХ-д болон Улаанбаатар хотын есөн дүүргийн сонгуулийн хороодод 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор цахимаар болон цаасаар хүргүүлсэн бөгөөд эдгээр нь доод шатны сонгуулийн хорооддоо хүргүүлжээ. Сонгогчдын нэрийн жагсаалт нь хуульд заасан хугацаанд буюу 6 дугаар сарын 5-ны өдрийн дотор ерөнхийдөө хүргэгдсэн байлаа.

СТХ-нд санал авах байр нь сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоог олгоно гэж заасан бөгөөд сонгогч өөрийн мэдээллийг биечлэн шалгах долоо хоногийн хугацаатай байдаг бөгөөд 6 дугаар сарын 11-ний дотор засвар оруулах хүсэлт гаргах эрхтэй ажээ. Гэвч ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажигласнаар энэхүү заалтыг тэр бүр ягштал биелүүлээгүй байх тохиолдолууд гарчээ. Сонгогчийн нэрийн жагсаалтыг сумын засаг захиргааны байранд хадгалах тохиолдлууд гарсан бөгөөд энэ нь сумын төвөөс алслагдмал суудаг орон нутгийн сонгогчдод мэдээллээ шалгахад нь хүндрэлтэй байлаа. Нөгөөтэйгүүр, зарим СДСХ, СХХ-д сонгогчийн нэрийн жагсаалт дахь мэдээллийг шалгах ажлыг идэвхтэй явуулж байсан нь сайшаалтай. СЕХ болон ОӨУБЕГ-ын зүгээс олон нийтэд хандан сонгогчдын нэрийн жагсаалт дахь мэдээллээ шалгахыг сонгогчдод уриалсан мэдээллийн компанит ажил явуулж байлаа.

¹⁶ ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагений Баримт бичгийн 24 дэх хэсэгт “ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан аливаа заалт нь холбогдох хуулийн аль нэг зорилттой уялдаж байхаас гадна тухайн хуулийнхаа зорилготой хатуу нийцэж байх ёстой” гэж заажээ. Мөн “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 25-р зүйлд өгсөн НҮБХЭХ-ны 25-р Ерөнхий тайлбарын 14 дэх хэсэгт “хэрэв гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл нь санал өгөх эрхийг нь түдгэлзүүлэх үндэс болсон бол ийнхүү түдгэлзүүлсэн хугацаа нь үйлдсэн гэмт хэрэг болон оногдуулсан ял шийтгэлтэй тохирч байх ёстой” гэжээ.

Сонгогч өөрийн байнга оршин суугаа газрын харьяа сонгуулийн хэсгээс өөр сонгуулийн хэсэг рүү шилжих бол 6 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө энэ тухай хүсэлтээ гаргах боломжтой. Ингэхдээ, сонгогч өөрийн оршин суугаа газрын харьяа сонгуулийн хэсэгт шилжих тухай хүсэлтээ гаргаад, улмаар шилжин очсон сонгуулийн хэсэгт бүртгүүлнэ. Сонгогчийн шилжилтийг аймаг дотор хийхийг хориглодог. Нийтдээ 1,927 сонгогч сонгуулийн хэсгээсээ шилжсэн байна. Санал өгөх газраа солих боломж иргэнд олгож буй нь сонгогчдын сонгох эрхэнд нөлөөлөх эерэг туршлага юм. Гэвч долоохон хоногийн хугацаанд сонгогч нь хоёр шаттай шилжилтийг амжиж хийх нь хүндрэлтэй асуудал бөгөөд энэ байдал нь уг журмыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна. Мөн сонгогчийн шилжилтийг аймаг дотор хийхийг хориглосон заалт нь ерөнхийлөгчийн сонгуульд бодит ач холбогдолгүй бөгөөд сонгогчийн сонгуулийн эрхийг хязгаарлах эрсдэлтэй байлаа.

Сонгогч сонгуулийн хэсэг хооронд шилжих явдал хоёр дахь санал хураалтад мөн адил хамаарч байсан боловч сонгогч оршин суугаа газрын харьяа сонгуулийн хэсгээс өөр сонгуулийн хэсэг рүү шилжих тухай шинээр хүсэлт гаргах, мөн анхан шатны санал хураалтын үеэр хийсэн шилжилтээ өөрчлөх ч боломжгүй байлаа. Хоёр дахь шатны санал хураалтыг зарлан товлосон өдөр болон санал авах өдрийн хооронд наймхан хоногийн хугацаа байсан тул ийнхүү сонгогчдын шилжилтийг хориглосон сонгуулийн байгууллагын эл шийдвэр нь оновчтой байх магадлалтай.

Санал хураалтын өдөр санал авах ажиллагаанд оролцож буй сонгуулийн хороо, цагдаагийн албан хаагчид, улсын бүртгэлийн байгууллагын ажилтнууд болон бусад ажилтнууд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх эрхтэй байжээ. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны уулзаж ярилцсан хүмүүс СХХ-ны ажилтнууд, ялангуяа цагдаагийн ажилтнуудыг санал авах өдрийн өмнөхөн дайчлагддаг тул ийнхүү саналаа өгөх боломж хязгаарлагдмал гэдэгт зовниж буйгаа илэрхийлж байв.

Сонгогчийн нэрийн жагсаалтыг үйлдэхэд хэрэглэж буй технологийн хүчин чадлыг харгалзан сонгогчдын шилжилт хөдөлгөөн хийх үйл явцыг хялбаршуулах боломжтой. Сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг аймаг дотор хийхийг хориглосон заалт нь ерөнхийлөгчийн сонгуульд бодит ач холбогдолгүй тул эргэн харах нь зүйтэй.

Анхан шатны санал хураалтад нийт 1,978,298 сонгогч сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн. Ийнхүү сонгогчдын нэрийн жагсаалт үйлдсэнээс хойшхи хугацаанд нас барсан иргэдийн хасах, түүнчлэн 7 дугаар сарын 7-ны өдрөөс өмнө 18 нас хүрч буй сонгуулийн насны иргэдийг нэмэх зэрэг өөрчлөлтийг хоёр дахь санал хураалтын өмнө сонгуулийн нэрийн жагсаалтад оруулжээ. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны уулзаж ярилцсан хүмүүс сонгогчид дээрх шинэчилэгдсэн нэрийн жагсаалттай дахин танилцаж болох эсэх тал дээр санал зөрөлдөж байлаа. Бодит байдал дээр уг шинэчилэгдсэн нэрийн жагсаалт нь ихэнх СХХ-дод хоёр дахь санал хураалтын өдрөөс хэдхэн хоногийн өмнө хүргэгдсэн бөгөөд сонгогчдод үүнтэй танилцах боломж үндсэндээ хомс байлаа.¹⁷ Долдугаар сарын 6-ны өдөр СЕХ сонгогчдын нэрийн жагсаалтад нийт 1,982,733 сонгогч бүртгэгдсэн гэж мэдээлэв. Хоёр дахь санал хураалтын дүнгээр нийтдээ 1,983,588 сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн буюу сонгогчийн нэрийн жагсаалт 5000 гаруй сонгогчоор нэмэгдсэн байлаа.¹⁸

Гадаад улсад байгаа иргэд сонгуульд оролцох бүртгэлээ оршин суугаа улсад байгаа дипломат төлөөлөгчийн газарт 5 дугаар сарын 1-нээс 20-ны өдрүүдэд хийх шаардлагатай байв. Өмнөх Ерөнхийлөгчийн сонгуульд оролцохоо сонгогч заавал биечлэн очиж бүртгүүлдэг байсан бол энэ

¹⁷ Сонгогчид сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ цахим бүртгэлд орж шалгах боломжтой байв.
¹⁸ СЕХ болон ОӨУБЕГ-ын мэдээлснээр дээрх өөрчлөлт нь 18 нас хүрсэн сонгуулийн насны иргэдийг нэмж, жагсаалт дахь “түр хасав” тэмдэглэгээтэй сонгогчдын бүртгэлийг сэргээсэн зэрэгтэй холбоотой.

удаад цахим хэлбэрээр бүртгүүлэх боломжтой байжээ. Нийт 7,209 сонгогч гадаад улсад саналаа өгөхөөр бүртгүүлжээ.¹⁹

Сонгуульд оролцогч талууд ерөнхийдөө сонгогчийн бүртгэлийн явцын үнэн зөв, сонгогчдыг ялгаварлахгүйгээр хамруулсан гэдэгт итгэж буйгаа илэрхийлсэн. Гэвч зарим нэг олны танил хүмүүсийн хийсэн мэдэгдэл, үүний дотор АН-ын өндөр албан тушаалтан сонгогчдын нэрийн жагсаалтыг будилантай байх магадлалтай тул үнэн зөвд эргэлзэж буйгаа илэрхийлсэн зэрэг нь энэ итгэлийг зарим талаар буруулсан.²⁰ Энэ эргэлзээг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон иргэний нийгмийн байгууллагууд мөн илэрхийлж байлаа. Сонгогчийн нэрийн жагсаалтын цахим хувилбарыг улс төрийн намуудад хүргүүлсэн хэдий ч иргэний нийгмийн байгууллагуудад тус жагсаалтад бие даасан, хараат бус шалтгалт хийх боломж олдоогүй.

Сонгогчийн бүртгэлийн явцад итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор сонгогчийн нэрийн жагсаалтад хараат бус шалгалтыг иргэний нийгмийн байгууллага, эсвэл хараат бус гуравдагч байгууллагаар хийлгэж, шалгалтын дүнг олон нийтэд мэдээлэх нь зүйтэй.

VIII. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

УИХ-д суудалтай гурван намыг төлөөлсөн гурван нэр дэвшигч энэ удаагийн сонгуульд бүртгэгдсэн. Бусад нам нэр дэвшүүлэх эрхгүй бөгөөд бие даан нэр дэвшихийг хуулиар зөвшөөрдөггүй. Эрх бүхий нэр дэвшигч нь 45 нас хүрсэн, Монгол Улсын харьяат эцэг эхээс төрж, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан байх ёстой. Нэр дэвшигч нь зээл, барьцаа, хугацаа хэтэрсэн албан татварын өр төлбөр, эсвэл эрүүгийн гэмт хэргийн бүртгэлгүй байх шаардлагатай. ЕАБХАБ/АИХЭГ-аас одоогийн тавигдаж буй шаардлагууд хэтэрхий хатуу, нэн ялангуяа бие даан нэр дэвших эрхийн тухай заалт алга байгаа талаар өмнө нь байр сууриа илэрхийлж байсан. Энэ нь мөн сонгогдох эрхийн тухай ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй нийцэхгүй, сонгогчдын сонголтыг хязгаарлаж байна.²¹

Бие даан нэр дэвшихийг зөвшөөрдөггүй болон УИХ-д суудалгүй нам нэр дэвшүүлэх эрхгүй гэх мэт сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлаж байгаа зохимжгүй хязгаарлалтуудыг өөрчлөх нь зүйтэй. Мөн эх орондоо байнга оршин суусан байх шаардлагыг эргэж харах нь зохистой.

Тус сонгуулийн товыг 1 дүгээр сарын 26-ны өдөр зарласан хэдий ч улс төрийн намууд зөвхөн 5 дугаар сараас эхлэн нэр дэвшигчдийнхээ нэрийг дэвшүүлэх эрхтэй бөгөөд СЕХ нь гуравхан хоногийн дотор нэр дэвшигчдийг бүртгэх эсэхийг шийдвэрлэж байлаа. Энэхүү давчуу хугацаа нь олон тооны сөрөг үзэгдэл дагуулж байна. Тухайлбал, улс төрийн намуудын хувьд нэр дэвшигчийн сунгаагаа явуулах, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм болон олон нийтийн хяналтаа хэрэгжүүлэх хугацааг хязгаарлаж байна.

¹⁹ Хоёр дахь санал хураалтын үеэр уг тоо буурч 7,163 сонгогч болов. 6-р сарын сүүлээр гурван дипломат төлөөлөгчийн газар хаагдаж, санал авах үйл ажиллагааг явуулсангүй.

²⁰ АН-ын өндөр албан тушаалтан сонгогчийн нэрийн жагсаалт будилаантай гэх мэдэгдэл хийж, улмаар сонгогчдыг дахин санал өгөхөөс сэргийлж саналаа өгсөн сонгогчдын хуруунд тусгай тэмдэглэгээ хийхийг СЕХ-ноос шаардав. АН-аас нэр дэвшигч эл асуудлаар санаа зовниж буйгаа ЕАБХАБ/АИХЭГ-ийн САХХ-нд илэрхийлж байлаа.

²¹ “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 25-р зүйлд өгсөн НҮБХЭХ-ны 25-р Ерөнхий тайлбарын 15 дахь хэсэгт “Сонгогдох эрх эдлэх боломжгүй хүмүүсээс бусад хүмүүс нь боловсрол, оршин суугаа газар, гарал үүсэл, эсвэл улс төрийн харъяаллын шалтгаан гэх мэт үндэслэлээр ялгаварлан гадуурхагдах ёсгүй” гэж заасан байдаг. ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагений Баримт бичгийн 7.5 дахь хэсэгт “Гишүүн орнууд нь иргэдийн улс төрийн болон нийтийн албан тушаал хаших эрхийг ялгаварлан гадуурхалгүйгээр хүндэтгэнэ” гэж заажээ. Цаашлаад 24 дэх хэсэгт эрх, эрх чөлөөг хязгаарлах хязгаарлалтууд нь “тухайн хуулийн зорилготой хатуу нийцэж байх ёстой” гэжээ. Мөн Сайн туршлагын дүрмийн II.1.b хэсгийг үзнэ үү.

Түүнчлэн энэ байдал нь сонгуулийн сурталчилгааг зохицуулсан журмаас, үүний дотор сонгуулийн зардлын хязгаартай холбоотой зүйл заалтаас эвтэйхэн зайлсхийж, сонгуулийн сурталчилгааг хуульд заасан хугацаанаас өмнө эхлүүлэхэд хүргэж байна.

СЕХ улс төрийн намуудаас нэр дэвшигчдийн материалыг хүлээн авсны дараа АН болон МАН-ын нэр дэвшигчдийг бүртгэж, харин МАХН-аас нэр дэвшигчийг нэр дэвшихээс өмнөх хугацаанд Монгол Улсад байнга оршин суугаагүй гэх үндэслэлээр бүртгэхээс татгалзсан. МАХН энэ шийдвэрийг давж заалдахаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан ч, 6 дугаар сарын 9-ний өдөр шүүхээр хэлэлцээд, СЕХ-ны шийдвэрийг хэвээр үлдээсэн. МАХН эл шийдвэрийг давж заалдахаар Улсын дээд шүүхэд гомдол гаргасан боловч анхан шатны сонгуулийн санал авах өдрийн дараа л хэлэлцэгдэж, хэрэгсэхгүй болов. МАХН-ын энэхүү хэрэг нь иргэдийн хуулиар хамгаалуулах эрхийг зөрчиж буй явдал бөгөөд цаашид сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг хянан хэлэлцэх хугацааг богиносгох хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.²² МАХН-ын анхны нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсаны дараа тус нам хуульд заасан хугацаанд багтаан өөр нэр дэвшигчийг нөхөн дэвшүүлсэн ба СЕХ уг нэр дэвшигчийг албан ёсоор бүртгэж авсан.

Сонгуульд нэр дэвшигчийг нэр дэвшүүлэх хугацааг сунгаж, сонгуулийн хуанлид эрт оруулах зохицуулалтыг хийж, нэр дэвшигчийг бүртгэх, зохих шалгалтыг хийх болон давж заалдах хангалттай хугацааг бүрдүүлж өгөх нь зүйтэй.

IX. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ОРЧИН

Нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа 6 дугаар сарын 6-ны өдөр эхэлсэн бөгөөд анхан шатны сонгуулийн санал хураалт авах өдрөөс 24 цагийн өмнө дууссан. СТХ-иар зөвхөн сонгуулийн анхан шатны санал хураалтын үед сонгуулийн сурталчилгааг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулж өгсөн байна. Харин сонгуулийн хоёр дахь санал хураалтын үеэрх-сонгуулийн сурталчилгааны тухайд хуулийн хийдэл байгаа нь ажиглагдав. Уг асуудал дээр сонгуульд оролцогч талууд болон СЕХ-ны зүгээс ч хориглоно гэсэн тайлбарыг хийж байсан тул анхан шатны санал хураалтын дараа сонгуулийн сурталчилгаа албан ёсоор зогсож, үл анзаарагдах, гуравдагч талын сурталчилгааны хэлбэрүүдээр үргэлжилж байлаа.

Сонгуулийн нэг ба хоёр дахь шатны санал хураалтын хооронд сонгуулийн сурталчилгаа явуулах хугацааг зөвшөөрөх талаар бодолцох нь зүйтэй.

Нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг Үндэсний аудитын газар (ҮАГ)-аас Монгол Улсын эдийн засаг, хөгжлийн бодлогод нийцэж байгаа эсэхийг шалган, урьдчилан батлах ёстой байгаа нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, улс төрийн олон ургалч үзлийг шаардлагагүйгээр хязгаарлаж буй явдал юм. Тавдугаар сарын эхээр ерөнхийлөгчийн сонгуульд оролцож буй гурван нам мөрийн хөтөлбөрөө ҮАГ-т өгчээ. Намуудын мөрийн хөтөлбөрт нийт 208 зорилт тусгагдсанаас 41 зорилтыг нь ҮАГ зохих засвар өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай гэж үзжээ. Намуудын зохих засвар өөрчлөлтүүд оруулсан мөрийн хөтөлбөрүүдийг 5 дугаар сарын 10-ны өдөр дахин хүргүүлжээ.²³

Хэдийгээр МАХН, МАН, АН өөрсдийгөө зүүн, зүүн-төвийн, баруун-төвийн үзэл баримтлалтай гэх боловч нэр дэвшигчдийн хувьд үзэл суртлын ялгаа бараг мэдрэгдсэнгүй. МАН-ын нэр дэвшигч нь эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулж буй өөрийн намын амжилтуудыг онцлох байдлаар нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах тухай мөрийн хөтөлбөрөөрөө

²² ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагений Баримт бичгийн 5.10 дахь хэсэгт “үндсэн суурь эрхийг хүндэтгэж, хууль эрх зүйн шударга байдлыг хангах үүднээс хүн бүр захиргааны гаргасан шийдвэрийг эсэргүүцэн барагдуулах үр дүнтэй арга хэрэгслийг авах эрхтэй байна” гэж заажээ.

²³ МАХН-ын анхны нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсаны дараа тус нам нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө дахин хүргүүлэх хэрэгтэй болсон. Улмаар ҮАГ тус хөтөлбөрийг нь батлав.

сурталчилгаа явуулсан. Харин АН болон МАХН-ын нэр дэвшигчид авилгатай холбоотой асуудлууд, мөн ядуурал, гадныхны ашиг сонирхолд үйлчлэх, уул уурхайн орлогын шударга бус хуваарилалт зэрэг асуудлууд дээр төвлөрч байлаа. Сонгуулийн сурталчилгаа ерөнхийдөө сөрөг агуулгатай байсан бөгөөд АН болон МАХН-ын нэр дэвшигчдийн сурталчилгаа тэр талаараа илүү ялгарч байв.

Анхан шатны санал хураалтын үеэрх сонгуулийн сурталчилгаа өрсөлдөөнтэй явагдаж, иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж чадлаа. Нэр дэвшигчид нийслэл Улаанбаатар хот болон 21 аймгаар богино хугацаанд явж, сонгуулийн сурталчилгааны хурал цуглаануудад оролцон, иргэд сонгогчидтой уулзлаа. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ нь сум, багийн хэмжээнд зохион байгуулагдсан улс төрийн үйл ажиллагааг оролцуулаад нийт 60 хурал цуглааныг ажиглалаа. МАН болон АН-аас зохион байгуулсан сонгуулийн сурталчилгааны хурал уулзалтууд дээр заал танхимуудыг тухайн аймаг дахь намуудын зуу зуун дэмжигчид дүүргэж, үйл явдлыг том дэлгэцээр гадаа байгаа хүмүүст зориулж шууд дамжуулж байв.²⁴ Ерөнхийдөө МАН болон АН-ын сурталчилгааны хурал уулзалтууд зохион байгуулалт өндөртэй болж байлаа. Хэдийгээр МАХН-ын хурал цуглаануудын цар хүрээ харьцангуй жижиг байсан ч, нэр дэвшигч сонгогчидтой нүүр тулж уулзах илүү боломжтой, харьцангуй чөлөөтэй болж байв.

Орон нутгийн засаг захиргаа нь гадаа сурталчилгааны зурагт самбар байрлуулах болон сурталчилгааны хурал цуглаан хийх газруудыг хуваарилахад чухал үүрэг гүйцэтгэж байлаа. Улс төрийн нам болгон аймгийн төвүүд дээр гэр барьж, намын дэмжигчид сурталчилгааны материал тарааж байв. Гадаах сурталчилгаа 6 дугаар сарын 6-ны өдрөөс хойш төвийн хэсгүүдээр ихэссэн. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажигласнаар бусад нэр дэвшигчидтэй харьцуулахад МАН-ын нэр дэвшигчийн зурагт самбарын тоо илт илүү байв.²⁵ МАХН ялангуяа зарлалын самбарууд байршуулах цэгүүдийг ялгавартай хуваарилж байгаа талаар дурдаж байсан хэдий ч, санхүүгийн шалтгаанаар харьцангуй даруухан сурталчилгаа явуулж буйгаа хүлээн зөвшөөрч байлаа.²⁶ Хоёр дахь санал хураалтын өмнө гадаах сурталчилгааны зурагт самбаруудыг хураасан бөгөөд олон нийтийг хамарсан хурал цуглаан зохион байгуулахыг зогсоож, оронд нь “айлаас айлд” хүрэх байдлаар сурталчилгаа явагдав.²⁷

Сонгуульд нэрээ дэвшүүлсэн хоёр нэр дэвшигчийг хууль бус үйл ажиллагаанд холбогдсон гэх дүрс бичлэгүүд олон нийтэд цацагдсан нь эл сонгуулийн сурталчилгааны содон дүр зураг байлаа.²⁸ Эдгээр нь МАН-ын нэр дэвшигчийн төрийн албыг хууль бусаар зарсан гэх, мөн МАХН-ын нэр дэвшигчийн гадны шашны байгууллагаас сонгуулийн сурталчилгааны хандив авсан гэх дүрстэй болон аудио бичлэгүүд байлаа.²⁹ Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг хэлэлцэхээс илүүтэй дээрх бичлэгүүдийг жинхэнэ эсэх, авилга хээл хахууль авсан, төрийн албыг наймаалцсан гэх мэдэгдлүүд нь сонгуулийн сурталчилгааны үеэр хэлэлцэгдсэн гол сэдвүүд болж байлаа.

²⁴ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны тооцоолсноор хамгийн том хэмжээний сонгуулийн сурталчилгааны цуглаанд 4,500 орчим хүн оролцсон Улаанбаатар хотод болсон АН-ын цуглаан байв. Харин орон нутаг зарим цуглаанд 40-50 хүн, аймгийн төвүүдэд 400-аас 800 орчим хүн оролцож байв.

²⁵ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ 10 аймгийн төвийг хамарсан гадаах сурталчилгаанд тоон үнэлгээ хийсэн байна. Уг судалгаагаар нийт сурталчилгааны самбар болон зурагт хуудаснуудын 48% МАН, 33% АН, харин 18% МАХН-ынх байв.

²⁶ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд мэдээлснээр Өмнөговь, Архангай, Хөвсгөл аймгууд болон Улаанбаатар хотод байлаа.

²⁷ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчид зурагт хуудсыг хураагаагүй байсан нэг тохиолдол бүртгэв.

²⁸ Дүрс бичлэгүүд анхандаа нийгмийн сүлжээгээр нилээд гарч байгаад ба хожим нь телевизээр гарах болсон.

²⁹ Тухайлбал, 6-р сарын 16-нд МАХН-ын нэр дэвшигчийн гадны шашны байгууллагаас 60 сая БНСУ-ын вон сонгуулийн сурталчилгааны хандив болгож авсан гэх дүрс болон аудио бичлэгүүд нийгмийн сүлжээгээр анх гарч эхэлсэн. Дээрх дүрс бичлэгийг нэр дэвшигчийн гэрт хийсэн гэж байв. Энэүү дүрс бичлэгийг хожим нь МАН телевизийн нэвтрүүлгээр төлбөртэй сурталчилгаа хэлбэрээр гаргасан.

Сонгуулийн сурталчилгааны үеэр нийгмийн сүлжээ чухал үүрэг гүйцэтгэлээ. Бүх нэр дэвшигч өөрийн нүүр ном буюу Facebook хуудас, МАН болон АН-ын нэр дэвшигчид жиргээ буюу Twitter болон хувийн цахим хуудсаа ашиглаж, сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаагаа сурталчилсан байна. АН-ын нэр дэвшигч нөгөө хоёр нэр дэвшигч нийлээд хүрэхээргүй хэмжээний их хандалттай байв.³⁰ МАН болон АН-аас сонгогчдод нийгмийн сүлжээнд идэвхтэй оролцох боломж олгох үүднээс гар утасны аппликейшнийг гаргажээ. Мөн нийгмийн сүлжээнд дэх сонгогчдын оролцоог нэмэгдүүлэх, хүрээг нь тэлэх зорилгоор АН болон МАХН-аас Facebook шууд дамжуулалтыг өргөн ашиглаж байлаа. Хоёр дахь санал хураалтын өмнө нэр дэвшигчид өөрсдийн албан ёсны цахим хаягууд дээрээ сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааг хөндөхөөс ерөнхийдөө зайлсхийж байлаа. Харин гуравдагч этгээдийн цахим хаяг болон вэб хуудсыг ашиглан нэр дэвшигчдийн сурталчилгаа үргэлжилсээр байв. Үүний сацуу, хоёр дахь санал хураалтын өмнө төлбөртэй, улс төрийн агуулга бүхий мэдээлэл нийгмийн сүлжээнд мэдэгдэхүйц ажиглагдсан. Нийгмийн сүлжээг сонгуулийн луйврын талаар сэжиглэж буй мэдээллээ тараах, мөн сонгуулийн үйл явц шударга явагдаж буйд эргэлзээ төрүүлэх зорилгод өргөн ашиглаж байлаа.³¹

Төрийн захиргааны байгууллагын албан ёсны үйл ажиллагаа болон улс төрийн сурталчилгааны хоорондох зааг ялгааг сонгуулийн нийт хугацааны турш баримтласангүй. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажилласан аймгуудад зохион байгуулагдсан МАН-ын бараг бүх цуглаанд тухайн намын харьяалалтай засаг дарга нар оролцож байлаа.³² ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд төрийн байгууллагын өмч хөрөнгийг буруугаар ашигласан тохиолдлууд гарч байгаа талаар мэдээллүүд ирж байсан бөгөөд зарим үед ийм үйлдлүүд шууд ажиглагдаж байв.³³ Сонгуулийн сурталчилгааны цуглаануудад төрийн албан хаагчид, нэг тохиолдолд цэргийн албан хаагчид оролцсон хууль бус үйлдлүүд ажиглагдаж байв.³⁴ МАН-ын цуглаануудад засгийн газрын гишүүд мөн оролцож байлаа.

Сонгуулийн хоёр дахь шатны санал хураалт болохоос өмнөхөн МАН-ын нэр дэвшигч өөрийн хашиж буй УИХ-ын даргын албан тушаалаа ашиглаж, нийгмийн тулгамдсан асуудлуудыг хөндөхийн сацуу төрийн эрх барьж буй өөрийн намын үйл ажиллагааг сурталчилсан мэдэгдэл хийжээ.³⁵ Үүнээс гадна 7 дугаар сарын 4-ны өдөр засгийн газар нилээд маргаан дагуулсан, сонгуультай холбоотой байх магадлал өндөр хэд хэдэн шийдвэр гаргасан. Жишээлбэл, үүнд төрийн өмчит хүдэр олборлох, баяжуулах үйлдвэрийн хувьцааг иргэдэд хуваарилах, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийн тээврээр үйлчлэхэд хөнгөлөлт олгох, цахилгаан эрчим хүчний тарифыг бууруулах болон хүүхдийн мөнгө олгох зэрэг шийдвэрүүд байлаа. Долдугаар сарын 6-7-ны хооронд хүүхдийн мөнгө олгоход 161,5 тэрбум төгрөг

³⁰ АН-ын нэр дэвшигчийн Facebook хаяг нь 360,000 хандалттай, МАХН-ын нэр дэвшигч – 140,000 гаруй хандалттай, харин МАН-ын нэр дэвшигч – 110,000 орчим хандалттай байв. Twitter-ийн жиргээний тухайд: АН - 252,000 хандалттай, МАН – 40,000 хандалттай байлаа. МАХН-ын тухайд Twitter хаяг нэгээгүй ажээ.

³¹ Тухайлбал, МАН-ын харьяалалтай Эрүүл мэндийн сайд яамныхаа харьяа эмнэлгийн ажигнуудыг хөдөө орон нутагт сонгуулийн сурталчилгаанд явуулсан гэж буруутгагдаж байв. Түүнчлэн сонгогчдын саналын худалдан авсан, АН-ын сонгогчдыг цагдаагийн байгууллага дарамталсан гэх агуулагтай дүрс бичлэгүүд байлаа.

³² Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дархан, Хэнтий, Ховд, Хөвсгөл, Сүхбаатар, Өмнөговь, Увс зэрэг аймагт. Тухайлбал, Засгийн газрын гишүүд Улаанбаатар хот болон Ховд аймагт сонгуулийн цуглаанд оролцож байгаа нь харагдсан.

³³ Тухайлбал, Говь-Алтай аймгийн засаг дарга албаны унаатайгаа тав хоног сумдаар явсан байна. Мөн Баянхонгор аймгийн засаг даргын Facebook-ын хуудас МАН-ын сонгуулийн материалуудыг сурталчилж байв.

³⁴ 6-р сарын 13-нд Баянхонгор аймагт болсон МАН-ын сонгуулийн цуглаан.

³⁵ МАН-ын нэр дэвшигч 7-р сарын 6-ны УИХ-ын хаврын чуулганы хаалт дээр хэлсэн үгэндээ засгийн гарын ололт амжилтыг дурдан, өөрийн сонгуулийн сурталчилгааны уриаг битүүгээр хэлж, АН-ыг шүүмжлэв. Түүний хэлсэн үгийг сонгуулийн өдөр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хэсэгчлэн цацсан бөгөөд Өдрийн сонинд хэвлэн нийтэлжээ. Тэрбээр мөн 6-р сарын 30-нд парламентын чуулган дээр үг хэлсэн.

тараажээ.³⁶ Ийнхүү улсын төсөвт гэнэт өөрчлөлт оруулж, төсвийн мөнгийг зарцуулсан явдал нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 9-р зүйлийг зөрчиж, улс төрийн нам болон төрийн захиргааны хоорондын зааг ялгааг бүдэгрүүлэхийн сацуу ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагений Баримт бичгийн 5.4 заалттай харшилж байна.³⁷

Төрийн албан хаагчид сонгуулийн сурталчилгаанд оролцохыг хязгаарлах зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тодорхой оруулах нь зүйтэй. Үүний сацуу эдгээрийн хэрэгжилтийг хангах механизмыг мөн тогтоох нь зохиостой.

АН нэр дэвшигчээрээ дамжуулж иргэдийг нэг удаа өрийн дарамтаас гаргах амлалтыг олон нийтэд хийсэн нь сонгуулийн жил эхэлснээс хойш сонгогчдын саналыг татах зорилгоор бэлэн мөнгө, эд зүйл тараах, амлахыг хориглосон СТХ-ийн заалттай зөрчилдөж байв. Уг байр суурь нь нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй байсан бөгөөд энэ нь далд сурталчилгааны нэг жишээг харуулж байна.

Нийгэм, улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны асуудал нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаанд ч, мөн хэвлэл мэдээллээр ч бараг хөндөгдөөгүй. Гурван нэр дэвшигч бүгд эрэгтэйчүүд байлаа. Хэдий тийм боловч жендэрийн тэгш байдлыг хангах талаар МАН болон АН-ын мөрийн хөтөлбөрт тусгагдсан бол, МАХН-ын мөрийн хөтөлбөрт энэ асуудлыг хөндсөнгүй. Ажиглалт хийсэн сонгуулийн сурталчилгааны цуглаануудад оролцсон хүмүүсийн 50 орчим хувь нь, мөн бага тушаалын сонгуулийн менежерүүд дунд олон эмэгтэйчүүд байв.

Сонгуулийн сурталчилгаа ерөнхийдөө монгол хэл дээр явагдав. Сонгуулийн сурталчилгааны материалыг казах хэл дээр орчуулж, мөн энэ хэл дээр сонгогчдод хандаж үг хэлсэн хэд хэдэн тохиолдол зөвхөн казах үндэстэн голдуу оршин суудаг Баян-Өлгий аймагт ажиглагдсан. Сонгуулийн сурталчилгааны үеэр үндэсний цөөнхүүдийн талаарх асуудал ерөнхийдөө хөндөгдөөгүй өнгөрсөн байна. Гэсэн хэдий ч үндэс, угсаа гаралтай холбоотой асуудлууд, ялангуяа МАН-ын нэр дэвшигчийг хятад гаралтай гэх мэдээлэл өргөнөөр тарааж байсан явдал нь сонгуулийн сурталчилгааны орчинд сөргөөр нөлөөлсөн.

Х. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ

Нэр дэвшигчдийн хоёр нь (АН болон МАХН) нэрээ дэвшүүлэхэд өөрсдийн улс төрийн намуудад мөнгөн хандив өгөв.³⁸ Сонгуулийн сурталчилгааг хандиваар болон нэр дэвшигчдийн хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн. СТХ-иар хандивын хэмжээг иргэний хувьд 3 хүртэл сая төгрөг, хуулийн этгээдийн хувьд 15 хүртэл сая төгрөг байхаар хязгаарлажээ. Мөнгөн бус хандивыг зардлын хязгаараар тогтоогдож, харин бэлэн мөнгөөр өгч буй бүх хандив нь тодорхой банкны дансаар дамжуулан хийгдэх ёстой байв. Аймгуудад ихэнх сонгуулийн сурталчилгааны зардлыг намын төв байраас хуваарилсан хөрөнгөнөөс гаргасан, мөн намууд дотоодоосоо хөрөнгө босгосон. АН болон МАХН-аас нэр дэвшигчид хандив цуглуулахдаа нийгмийн сүлжээ ашигласан бол, МАН хандив цуглуулах ажлаа сонин хэвлэлээр сурталчилжээ. Түүнчлэн МАХН-ын нэр дэвшигч сонгуулийн кампанит үйл ажиллагааны үеэрээ бэлэн мөнгөний хандив гуйсан байна.³⁹

³⁶ Ойролцоогоор 61.2 сая евротой тэнцэнэ; 1 евро ойролцоогоор 2,640 төгрөг.

³⁷ Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 9-р зүйл нь төрийн өмчийн хөрөнгөөр худалдан авалт хийх болон төрийн өмчийн хөрөнгийг захиран зарцуулахыг зохицуулдаг; 5.4-р заалт нь “улс төрийн нам болон төрийн захиргааны хоорондын зааг ялгааг тодорхой байлгах ёстой” гэж заажээ. 2016 оны ЕАБХАБ/АИХЭГ-ын болон Венецийн комиссын холбогдох удирдамжтай мөн танилцана уу.

³⁸ Тухайлбал, АН-ын хоёр нэр дэвшигч өөрийн намын нэр дэвшигчийг тодруулах сунгаанаас нэрээ татсан. Үүний сацуу МАХН-ын нэг нэр дэвшигч дотоод сунгаанаас нэрээ татжээ.

³⁹ Хандив өгсөн хүмүүсийн овог нэр, регистрийн дугаарыг авч, дараа нь цугларсан бэлэн мөнгийг банкинд дахь сонгуулийн сурталчилгааны дансанд хийжээ.

Авилгатай тэмцэх газар (АТГ)-аас 6 дугаар сарын 14-ны өдөр гурван нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг олон нийтэд зарласан. Нэр дэвшигчид хөрөнгө, орлогын мэдүүлэгтээ өөрийн болон гэр бүлийн орлого, эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө, унаа тэрэг, аж ахуйн нэгжийн хувьцаа, малын тоо толгой зэрэг харьцангуй дэлгэрэнгүй мэдээллийг тусгажээ.⁴⁰ Нэр дэвшигчид хөрөнгө, орлогын мэдүүлгээ өөрийн тооцоолж үнэлснээр гаргасан байна. Гэсэн хэдий ч, эдгээр мэдүүлэгт эзэмшиж буй хөрөнгийн үнэлэмж, мөн ямар үндсэн хөрөнгө нэр дэвшигчдийн ойрын гэр бүлийн гишүүдийн эзэмшилд байдгийг тодорхой зааж тусгаагүй байна. Дээрх байдал нь сонгогчдод нэр дэвшигчдийн санхүүгийн талаар үнэн зөв төсөөлөлтэй болох боломжийг олгохгүй байгаа төдийгүй нийтийн албанд сонгогдож буй хүмүүсийн ил тод, хариуцлагатай байдлын тараарх олон улсын сайн туршлагатай нийцэхгүй байна.⁴¹ Нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн үнэн зөв эсэхэд олон нийт АТГ-т хандан гомдол гаргах боломжтой. АТГ нь ийм гомдол хүлээж авснаас хойш 19 хоногийн дотор мөрдөн шалгах үүрэгтэй боловч шалгалттай холбоотой шийдвэр нь зөвхөн сонгууль дууссаны дараа л гарах байлаа. Хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой ямар нэгэн гомдол гаргасан тухай ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд мэдээлэл ирээгүй болно.

Ил тод байдлыг нэмэгдүүлж, олон нийтэд судалж, нягтлах болон гомдол гаргах хангалттай цаг хугацаа олгох үүднээс нэр дэвшигчдийн хөрөнгө орлого болон татварын мэдүүлгийг олон нийтэд эртнээс зарлах нь зүйтэй.

Нэр дэвшигчдэд өрсөлдөх боломж, нөхцөлийг ижил тэгш байлгахын тулд ҮАГ нь 2 дугаар сарын 24-нд сонгуулийн сурталчилгааны зардлын хязгаарыг 10.7 тэрбум төгрөг байхаар тогтоосноос 6.8 тэрбум төгрөг улс төрийн намаас, 3.9 тэрбум төгрөг нэр дэвшигчдээс гарахаар заажээ. Үүнд улс төрийн сурталчилгаанд 2.6 тэрбум төгрөг, шатахуунд 1.7 тэрбум төгрөг, сонгуулийн сурталчилгааны ажилчдын албан томилолтын зардалд 1.9 тэрбум төгрөг тус тус тусгажээ.⁴² Сонгуулийн сурталчилгаанд ажилласан хүмүүсийн цалин гэж тусад нь хуваарилсан зардал байхгүй ч, энэ нь зардлын төрлүүдээс хамгийн өндөр нь гэж үзжээ.⁴³

ҮАГ нь сурталчилгааны зардлын хязгаарыг тогтоохдоо хоёр дахь шатны санал хураалт явагдах магадлалыг тооцоолоогүй. Гэсэн хэдий ч МАН, АН болон МАХН-ын хувьд цөөн тооны сонгуулийн штабууд болон сурталчилгааны ажилтнууд ажилаж, нийгмийн сүлжээгээр сурталчилгаагаа явуулсаар байлаа. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны уулзаж, ярилцсан хүмүүсийн мэдээлснээр санхүүжилтийн улмаас сурталчилгаанд ажилласан зарим хүмүүст цалин хөлсийг нь өгөөгүй тохиолдууд байжээ.

ҮАГ нь анх удаа намуудын зардлын тайлангийн үнэн бодит эсэхийг тогтоохын тулд аймгуудад буй намуудын сонгуулийн штабуудад урьдчилан мэдэгдэлгүйгээр шалгалтыг анхан шатны сонгуулийн үеэр хийв. Гэвч ҮАГ-ын орон нутаг дахь салбаруудад төдийгүй намуудын хувьд тайлангийн загварыг сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө боловсруулаагүй байв. Мөн

⁴⁰ Авлигатай тэмцэх газраас мэдээлснээр АН-аас нэр дэвшигчийн хувийн орлого хамгийн өндөр (130 сая төгрөг), дараа нь МАН-аас нэр дэвшигч (91 сая төгрөг), МАХН-ийн нэр дэвшигч (23 сая төгрөг)-ний орлоготойгоор жагсжээ. Хэрэв гэр бүлийн орлогыг оруулбал МАН-аас нэр дэвшигч 209 сая төгрөгний орлоготойгоор эхэнд жагсаж, дараа нь АН-аас нэр дэвшигч 161 сая төгрөг, МАХН-аас нэр дэвшигч 128 сая төгрөгтэй тус тус жагсжээ.

⁴¹ 2003 оны НҮБ-ын Авилгын эсрэг конвенцийн 7.3-р заалтыг харгалзан "сонгуульт төрийн байгууллагад нэр дэвшүүлэх, улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгохын тулд хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээ авах талаар анхаарч үзэх"-ийг улс орнуудад үүрэг болгодог.

⁴² Албан томилолтын зардлыг нэр дэвшигч тус бүрт 13,939 сонгуулийн сурталчилгааны ажилтан байхаар гаргаж, нэг ажилтанд дунджаар 136 мянган төгрөг ноогдох ба энэ нь сонгуулийн сурталчилгааны ажилтны унаа, хоолны зардалд зориулагджээ.

⁴³ ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ-тай уулзаж ярилцсан хүмүүсийн тооцоолж буйгаар сонгуулийн сурталчилгааны ажилтнуудын цалин сонгуулийн сурталчилгааны бүхий л хугацаанд 100,000 төгрөгөөс 300,000 төгрөг байна.

сонгуулиас өмнө намуудын орлого, зардлын тайланг ил болгох тухай ямар нэг заалт байсангүйгээс гадна намуудаас аль нь ч сурталчилгааны зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг сайн дураар тайлагнасангүй. Тиймээс сонгуулийн сурталчилгааны үеэрх сурталчилгааны зардлыг шалгаж, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн журмыг зөрчсөн эсэхийг илрүүлж, зохих арга хэмжээг шуурхай авах боломжгүй байлаа.⁴⁴ Түүнчлэн сонгогчид санал өгөхөөсөө өмнө нэр дэвшигчдийн болон улс төрийн намуудын санхүүгийн байдлын талаар баталгаатай мэдээлэл авах боломжгүй байсан нь хариуцлагатай сонголт хийх болон нэр дэвшигчдэд хариуцлага тооцох боломжийг сонгогчдод олгосонгүй.

Сонгуулийн сурталчилгаа дуусгавар болохоос өмнө сонгуулийн сурталчилгааны орлого, зарлагын төсөөллийг ил болгож, цахим хэлбэрээр олон нийтэд мэдээлэх шаардлагыг нэр дэвшигчид болон улс төрийн намуудад тавихыг холбогдох эрх бүхий байгууллагууд санаачлах нь зүйтэй.

Санхүүгийн ил тод байдал болон хяналт дулимаг байгааг 6 дугаар сарын 23-ны өдөр цагдаагийн байгууллага АН-ын сонгуулийн сурталчилгаанд зориулсан 1,08 тэрбум төгрөгийн бэлэн мөнгө тээвэрлэж явсныг илрүүлсэн хэрэг харуулав. Цагдаагийн байгууллагаас энэ мөнгийг сонгогчдын саналыг худалдан авах зорилгоор ашиглахад хэрэглэх гэж байсан гэж мэдэгдэж байсан бол, харин АН-ын зүгээс баруун аймгуудад ажиллаж байгаа сонгуулийн сурталчиганы ажилтнуудад олгох цалинг тээвэрлэж явсан гэж тайлбарлажээ. АН нь нийт улс даяар 22,000 гаруй сурталчилгааны ажилтантай гэж мэдээлж байсан нь ҮАГ-ын тооцоолон гаргасан тооноос хоёр дахин илүү байв. Баруун аймгуудад ажиллаж байгаа сонгуулийн ажилтнуудад олгох гэж байсан гэх хураагдсан мөнгөний хэмжээ нь ҮАГ-аас сонгуулийн ажилтнуудад олгохоор тогтоосон өдөр тутмын үйл ажиллагааны нийт зардлын хэмжээний талаас илүү байжээ. Эндээс харахад зарим улс төрийн намуудын сонгуулийн сурталчилгааны зардал нь ҮАГ-аас тогтоосон сонгуулийн сурталчилгааны зардлын дээд хэмжээнээс хамаагүй илүү давж байсныг харуулж байна.

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид санхүүгийн тайлангаа сонгууль дууссанаас хойш 30 хоногийн дотор ҮАГ-т хүргүүлэх үүрэгтэй. Тайлан хүргүүлэхээсээ өмнө нэр дэвшигчид ҮАГ-аас магадлан итгэмжлэгдсэн 54 аудитын байгууллагын аль нэгийг сонгож тайландаа аудит хийлгэнэ. Дээрх хийгдсэн аудиттай холбоотой гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчлийн талаар хуулинд ямар нэгэн зохицуулалт алга байна. ҮАГ нь аудит хийгдсэн тайланд зөвхөн чанарын хяналт хийх үүрэгтэй ажээ. Үүнээс гадна энэ аудитын дүнг сонгуулийн дараа ч олон нийтэд ил тод зарлах тухай ямар нэгэн заалт байхгүй байна.⁴⁵ ҮАГ-аас нэр дэвшигчид болон улс төрийн намуудын зардалд аудит хийх өнөөгийн практик нь сонгуулийн сурталчилгааны зардлын ил тод байдлыг төдийлөн хангаж чадахгүй, үр ашиг муутай ажил болохыг харуулж байна.

Сонгуулийн сурталчилгааны дундуур болон дараах хугацаанд сонгуулийн сурталчилгааны зардлын зарцуулалтад үр дүнтэй хяналт тавих арга хэрэгслүүдийг ҮАГ-т олгох нь зүйтэй. ҮАГ-ын хийсэн аудитын урьдчилсан болон эцсийн тайлангуудыг олон нийтэд нийтэлж, тэр дундаа цахим хэлбэрээр мэдээлэх нь зохимжтой.

Сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлэх, мөн хуурамч санхүүгийн тайлан гаргах зэрэг сонгуулийн хуулийг ноцтой зөрчсөн үйлдлүүд огт шийтгэлгүй байна. Бусад зөрчлүүдэд оногдуулах торгууль мөн бага байна. Хандив өгөхийг хориглосон этгээд болох олон улсын байгууллага, үйлдвэрчний эвлэл, шашны болон бусад төрийн бус байгууллага зэргээс хандив авсан бол тухайн нэр дэвшигчийг нэр дэвшигчээс хасах хүртэл заалт бий. Гэвч нэгэнт

⁴⁴ Авлигын эсрэг конвенцийн 7 (3) зүйлд "оролцогч улс орон бүр сонгуульд төрийн байгууллагад нэр дэвшүүлэх, улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгохын тулд хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээ авах талаар анхаарч үзэх"-ыг санал болгодог. Улс төрийн намын зохицуулалтын тухай 194 дүгээр зүйлд "сонгогчид нь улс төрийн намуудыг хариуцлагатай байлгахын улс төрийн намуудад өгсөн санхүүгийн дэмжлэгийн талаар холбогдох мэдээлэлтэй байх ёстой" гэжээ.

⁴⁵ Тухайлбал, 2016 оны сонгуулийн санхүүгийн тайлангийн аудитын дүнг ил тод зарлаагүй байна.

сонгууль болоод өнгөрсөн хойно энэ заалтыг хэрэгжүүлэх боломжгүй. Ерөнхийдөө сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоотой зөрчлүүдэд оногдуулдаг арга хэмжээнүүд нь үр дүн муутай, тохиромжгүй байгаагийн зэрэгцээ сонгууль явуулах олон улсын сайн туршлагад зөвлөсний дагуу нэр дэвшигчдэд ижил тэгш өрсөлдөх боломж, нөхцөлийг хангаж өгөхгүй байна.

XI. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

A. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИН

Монгол Улсад 450 орчим хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байна. Мэдээлэл авах гол эх үүсвэр нь телевиз байгаа бол, хот суурин газарт интернет, ялангуяа нийгмийн сүлжээг өргөн дэлгэр ашиглаж байна. Сонин хэвлэл аажмаар уншигчдаа алдаж байна. Эдгээр байгууллагууд ашигтай ажиллах нь бараг ховор, үндсэндээ орлогынх нь мэдэгдэхүйц хувийг засгийн газрын захиалгат, төлбөртэй зар сурталчилгаа болон өмчлөгч эздийнхээ өгч буй санхүүгийн тэтгэмж, татаасаас хараат байна. Энэ байдал нь өөрийгөө хянах цензурт орох нөхцөлийг бий болгодог. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл, бүтэц бүрхэг байгаа нь олон улсын сайн туршлагатай зөрчилдөж байна.⁴⁶

Хэвлэл мэдээллийг зохицуулагч байгууллага нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эздийг тодорхой тогтоож, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгч эздийг нь олон нийтэд бүрэн ил тод болгох арга хэмжээг авах нь зүйтэй.

Монголын үндэсний олон нийтийн радио телевиз (МҮОНРТ) нь орон даяр нэвтрүүлгээ цацдаг үндсэндээ ганц хэвлэл мэдээллийн хэрэгсэл юм. МҮОНРТ нь реданкцийн бие даасан хараат бус байдлыг тодорхойлж өгдөг Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн тухай хуулиар зохицуулагддаг. Гэсэн хэдий ч, МҮОНРТ-ийн жилийн төсөв улс төрийн шийдвэрээс шалтгаалахын сацуу удирдлага нь улс төрийн нөлөөлөлд байдаг.⁴⁷ Ийм нөхцөл байдал нь МҮОНРТ-ийн хараат бус хөтөлбөрийн агуулга тодорхойлох чадавхийг боогдуулахаас гадна олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх зүйн болон санхүүгийн байдлын тухай олон улсын сайн туршлагатай нийцэхгүй байна.⁴⁸

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн санхүүгийн бие даасан болон тогтвортой байдлыг хамгаалсан хууль эрх зүйн хамгаалалтыг бий болгож, хараат бус байдлыг хангаж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлдэг болон цахим хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг зохицуулдаг гол байгууллага болно. ХХЗХ нь Монгол Улсад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, мэдээ мэдээллийн цахим хуудсын үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэхээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хариуцлага тооцох эрх бүхий этгээд юм. Тус хорооны дарга болон 6 гишүүнийг зургаан жилийн

⁴⁶ Европын Зөвлөлийн Парламентын ассамблейн 2065 (2015) зөвлөмж нь “ гишүүн орнууд хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгч эздийг нь олон нийтэд ил тод болгох зүйл заалтыг үндэсний хууль тогтоомжинд оруулах арга хэмжээг авах нь зүйтэй” гэж заажээ. Түүнчлэн, Европын Зөвлөлийн Парламентын ассамблейн 1636 (2008) зөвлөмжийн 8.18-р зүйл болон ЕЗ-ийн Сайд нарын зөвлөлийн CM/Res (2007)2 зөвлөмжүүдийг тус тус үзнэ үү.

⁴⁷ МҮОНРТ-ийн 2017 оны төсвийн орлогын 2/3-ыг улсын төсвөөс бүрдүүлжээ, гэсэн ч төсвийг жил бүр өөрчилдөг. Түүнчлэн 17 хувийг лицензийн төлбөрөөр, 15 орчим хувийг нь нэвтрүүлгийн цагийг зарж олохоор тооцжээ. Удирдлага нь дефакто төрийн албан тушаалтнууд ажээ. Жишээлбэл, одоогийн ерөнхий захирал нь 2016 оны орон нутгийн сонгуулийн дараа томилогдсон бөгөөд өмнө нь МАН-ын засгийн газрын хэвлэлийн төлөөлөгчийн албыг хашиж байжээ.

⁴⁸ ЕЗ-ийн Сайд нарын зөвлөлийн 34-ийн 16-рт гишүүн орнууд нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн санхүүгийн бие даасан байдлыг нь хамгаалсан хууль эрх зүйн хамгаалалтыг бий болгож, санхүүгийн хараат бус байдлыг хангаж, хэрэгжүүлэх ёстой гэж заажээ.

хугацаатайгаар ерөнхий сайд томилдог. Хорооны гишүүд албан тушаалаа хэрэгжүүлэх хугацаа нь төдийлөн баталгаагүй бөгөөд улс төрийн нөлөөлөлд өртөж, солигдох магадлалтай; 2016 оны УИХ-ын сонгуулийн дараа хорооны дөрвөн гишүүнийг сольжээ. Зохицуулах эрх бүхий байгууллагын бүтэц нь сайтар тогтоосон шалгуураар томилогддоггүй, улс төрийн хүчин зүйлст өртөмтгий байгаа нь олон улсын сайн туршлагатай нийцэхгүй байна.⁴⁹

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянах байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хамгаалахын тулд ХХЗХ-ны гишүүдийг томилж, чөлөөлөх журмыг эргэн харах нь зүйтэй.

В. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан хэдий ч хэвлэл мэдээллийн тухай хууль тогтоомжоор төдийлөн сайн хамгаалагдаагүй байна. Нэр төрийг гутаах, гүтгэх, худал мэдээлэл тараах зэргийг эрүүгийн шийтгэлээс 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс чөлөөлж, иргэний хариуцлагаар сольжээ. Гэвч хүний нэр төр гутаах, гүтгэх, худал мэдээлэл тараах зэрэгт оногдуулсан торгуулийн хэмжээ нь өндөр байгаа бөгөөд энэ нь интернетийн хувь хэрэглэгчдийн тавьж буй агуулгад мөн хамаарна. Үүний сацуу, нэр төр гутаах болон гүтгэх зэргийг тайлбарласан хуулийн тодорхойлолт нь бүрхэг байна.

Онлайн хэвлэлийн эрх чөлөөг хэтэрхий хязгаарлаж болзошгүй хуулийн зүйл заалтуудыг, мөн оногдуулж буй торгуулийн хэмжээ зэргийг эргэн харах нь зүйтэй.

СТХ нь хэвлэл мэдээллээр сонгуулийн сурталчилгааг тэнцвэртэй нэвтрүүлэхийг болон нэр дэвшигчдэд хэвлэл мэдээллийн орчинд ижил тэгш эрх олгохыг зохицуулсан. СТХ-иар нэг нэр дэвшигчид оногдох МҮОНРТ-ийн төлбөргүй нэвтрүүлгийн цагийг хуваарилаж, арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр төлбөртэй нэвтрүүлгийн цагийг ашиглах тухай зохицуулсан байдаг.⁵⁰ Гэвч уг хуулинд хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэвтрүүлгийн агуулгыг хязгаарласан зүйл заалтууд байсаар байна. Жишээ нь, СТХ-нд нэг нэр дэвшигчид оногдох мэдээний нэвтрүүлгийн цагийг өдөрт таван минут байхаар хязгаарлаж, санал асуулга нийтлэхийг хязгаарласан, хоорондоо зөрчилдсөн заалтууд агуулахаас гадна мэдээний нэвтрүүлгийн цагаар сурталчилгаа явуулахыг хоёрдмол утгатай тусгажээ. ХХЗХ-ноос үүнийг тайлбарлахдаа намуудын урьдчилан бэлтгэж төлбөртэй нэвтрүүлж буй мэдээ маягтай клипийг мэдээний цагаар нэвтрүүлэх нь улс төрийн сурталчилгаанд тооцогдохгүй гэв. Тиймээс үндэсний хэмжээнд болон Улаанбаатар хотод төвтэй телевизүүдийн ихэнх нь мэдээний нэвтрүүлгийн цагаа зарахаар санал болгожээ.⁵¹ Ийнхүү төлбөртэй, хуурамч мэдээний сегментүүд редакцийн агуулгаас ялгагдахгүй байсан нь сонгогчдод улс төрийн ухуулга, эсвэл шударга мэдээллийн аль нь болохыг ялгахад хэцүү байв.⁵²

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээний агуулга, санал асуулга нийтлэх, төлбөртэй нэвтрүүлгийн тухай заалтуудыг болон редакцийн агуулга, улс төрийн сурталчилгааны хоорондын зааг ялгааг тодорхой болгох нэмэлт өөрчлөлтийг СТХ-нд оруулах нь зүйтэй.

Хоёр дахь санал хураалтын өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн сурталчилгаа явуулах талаар СТХ-нд ямар нэгэн зохицуулалт алга байна. Зургаадугаар сарын 27-ны өдөр

⁴⁹ ЕЗ-ийн Сайд нарын зөвлөлийн (2007)23-р зөвлөмж нь томилгооны тодорхой шалгуурыг тогтоож, олон ургальч үзлийг хангаж, аль нэг улс төрийн хүчний нөлөөлөлд автахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь зүйтэй гэж заажээ.

⁵⁰ Нэр дэвшигч тус бүрт өдөр бүр 6 минутыг үнэ төлбөргүй мэдээний цагаар нэвтрүүлэхээр хуваарилсан бол төлбөртэй нэвтрүүлгэд 15 минутыг хуваарилжээ.

⁵¹ Нийт 46 үндэсний телевизийн болон Улаанбаатар хотод төвтэй телевизүүдийн 38 телевиз нь мэдээний нэвтрүүлгийн цагаа ХХЗХ-ноос тогтоосон үнэ тарифаар зарахаар санал болгожээ.

⁵² ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны хэвлэл мэдээллийн мониторингоор хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь редакцийн агуулга, улс төрийн сурталчилгааны хоорондын зааг ялгааг салгахгүй байсныг харуулжээ.

ХХЗХ-ноос сонгуулийн өдрийг дуустал улс төрийн сурталчилгаа болон нэр дэвшигчдийн талаар мэдээ, мэдээлэл нэвтрүүлэхгүй байх зөвлөмжийг гаргажээ.⁵³ Хуулийг ийнхүү өргөн утгаар тайлбарлан хэрэглэж буй явдал нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хумилаа.⁵⁴

ХХЗХ болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) нь сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн байгууллагууд хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавин ажиллав.⁵⁵ Хэдийгээр эдгээр хоёр байгууллагын хяналт тавих хууль эрх зүйн зохицуулалтууд заримдаа давхцаж байсан ч зөрчил гарсан тохиолдолд цаг тухайд нь үр дүнтэй арга хэмжээ авч чадсангүй. ХХЗХ нь зөвхөн радио телевизүүдийн төлбөртэй нэвтрүүлгийн цагийн хязгаар дээр мониторинг хийсэн бол, харин ШӨХТГ нь нэвтрүүлгийн агуулгад нь мониторинг хийж байлаа. ШӨХТГ-ын хувьд хангалттай санхүүжилгүйн улмаас цогц хэвлэл мэдээллийн мониторинг хийж чадаагүй бөгөөд заримдаа өрөөсгөл хориг, шийдвэрүүд гаргаж байлаа.⁵⁶ ШӨХТГ-аас анхан шатны сонгуулийн сурталчилгааны үеэр 20 сануулга хүргүүлснээс дийлэнх нь сөрөг сурталчилгааны үйл ажиллагаа болон санал асуулга онлайн аар нийтлэхтэй холбоотой байлаа. Хоёр дахь санал хураалтын өмнө ШӨХТГ-аас ХХЗХ-нд хандан хурц шүүмжилсэн агуулга бүхий нэвтрүүлэг гаргасан, хоосон саналын хуудас өгөхийг идэвхтэйгээр сурталчилсан гэх үндэслэлээр TV9 телевизийн тусгай зөвшөөрлийг сонгуулийн өдрийг дуустал цуцлахыг хүсэв.⁵⁷ Гэвч ШӨХТГ-ын үйл ажиллагаанаас ямар нэгэн мэдэгдэхүйц үр дүн гараагүй бөгөөд сануулга авсан хэвлэл мэдээллийн хэрэслийн аль нь ч нэвтрүүлгийн бодлогодоо өөрчлөлт оруулаагүй. ХХЗХ нь өөрийн хориг тавих эрхийг сонгуулийн үеэр хэрэгжүүлээгүй байна.

Хэвлэл мэдээлэлтэй холбоотой бүх зохицуулалтыг хэрхэн дагаж мөрдөж байгаад хяналт тавих, хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх үүрэг бүхий бие даасан хяналтын нэг төвлөрсөн байгууллагатай байх нь зүйтэй. Үүргээ үр дүнтэй биелүүлэхэд нь шаардлагатай хүний болон техникийн нөөц бололцоогоор энэхүү байгууллагыг хангах нь нэн чухал билээ.

С. ЕАБХАБ/АИХЭГ-ЫН САХХ-НЫ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГ

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ нь телевизийн болон хэвлэмэл мэдээллийн хэрэгслүүдийг түүвэрлэн авч, хэвлэл мэдээллийн мониторинг хийлээ.⁵⁸ Энэхүү хэвлэл мэдээллийн мониторинг нь давхар нийгмийн сүлжээнд дүн шинжилгээ хийсэн бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь нэр дэвшигчдэд өөрийн үзэл бодлоо илэрхийлж, өрсөлдөгчдөө шүүмжлэх үр нөлөөтэй тавцан болж өгсөн хэдий ч хянан шалгах үүргээ биелүүлж чадаагүй гэдгийг харууллаа.⁵⁹

⁵³ ХХЗХ нь дахин болон нэмэлт санал хураах ажиллагааг дуустал сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно гэсэн СТХ-ийн 70.9-р зүйлийг баримтлан ийнхү зөвлөмж гаргаснаа тайлбарлаж байлаа. Гэвч СТХ нь хоёр дахь шатны санал хураалтыг дахин сонгууль болон нэмэлт хураалт гэж тайлбарлаагүй байдаг.

⁵⁴ Ерөнхий тайлбарын 25-р зүйлийн 25-рт “Энэхүү 25-р зүйлд заасан эрхийг хангаж, улс төр, нийгмийн аливаа асуудлаар иргэд, нэр дэвшигчид, сонгогдсон төлөөлөгч нарын хооронд чөлөөтэй мэдээлэл солилцох байх нь нэн чухал” гэж заажээ. Ерөнхий тайлбарын 34-р зүйлийн 13-р заалтыг мөн үзнэ үү.

⁵⁵ СЕХ нь хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл, гомдлын асуудлыг шийдвэрлэх Хэвлэл мэдээллийн зөвлөлийг байгуулаагүй.

⁵⁶ Тухайлбал, таван телевизийн суваг авлигатай холбоотой гэх гэмт хэрэгт холбогдсон албан тушаалтнуудад хариуцлага хатуу тооцохыг уриалсан, ерөнхийдөө ижилхэн агуулагатай төлбөртэй нэвтрүүлэг цацсаны дараа ШӨХТГ-аас зөвхөн гуравт нь анхааруулга өгсөн байх жишээтэй.

⁵⁷ Сонгуулийн дараах үйл явц хэсэгтэй танилцана уу.

⁵⁸ ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ нь 5-р сарын 29-нд хэвлэл мэдээллийн мониторингоо эхлүүлсэн. Мониторинг хийгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь олон нийтийн радио телевиз (МУОНРТ), арилжааны телевизийн дөрвөн суваг (Ийгл ньюс, Монгол HD, ТВ5, ТВ9, С1) болон хувийн хэвшлийн таван сонин (Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ, Үнэн, Засгийн газрын мэдээ) болно.

⁵⁹ ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ нь улс төрийн намууд, нэр дэвшигчид, тоймчид болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн хөтөлж байсан Facebook-ийн 19 хуудас болон блогт мониторинг хийжээ. Хоёр санал хураалтын хооронд ийм Facebook хуудасны тоо 24 хүрч нэмэгдсэн байна.

Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө хэвлэл мэдээллээр нэр дэвшигчид болон нэр дэвшүүлж буй улс төрийн хүчний талаар харуулсан улс төрийн намын нэвтрүүлгүүд хэвлэл мэдээллийн редакцийн бодлогоор ч, төлбөртэй нэвтрүүлгийн хэлбэрээр ч цацагдаж байв. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд авилга хээл хахууль, гаднын ашиг сонирхолтой хуйвалдсан гэх нотлогдоогүй хардлагууд, мөн гаднынхныг гадуурхах, арьс өнгөөр ялгаварласан хэл яриа, хэт туйлшрал болон хүчирхийлэлд өдөөн турхирсан агуулга цацагдаж байсан нь ажиглагдсан.⁶⁰ Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэснээс хойш хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан нэвтрүүлгийн агуулга өөрчлөгдсөөр харилцан нэг нэгнийгээ буруушаасан хэлбэрт орсон.

Сонгуулийн албан ёсны сурталчилгааны үеэр МҮОНРТ нь хуульд заасны дагуу нэр дэвшигч тус бүрт үнэ төлбөргүй болон мэдээний нэвтрүүлгийн цагийг олгожээ. Гэвч мэдээний нэвтрүүлгүүд нь дүн шинжилгээтэй агуулгаар дутагдаж, гол төлөв намуудаас ирүүлсэн сонгуулийн сурталчилгааны үйл явдлын мэдээнээс бүрдэж байлаа. Үүнээс гадна, МҮОНРТ-ийн мэдээний нэвтрүүлгийн цагийн 20 гаруй хувь нь МАН-ын тэргүүлж буй засгийн газрын үйл ажиллагааны талаар байсан нь сонгогчдыг сонгуулийн өдөр мэдээлэлд үндэслэсэн сонголт хийхэд тус болсонгүй.

Сонгуулийн хоёр санал хураалтын хоорондох хугацаанд МҮОНРТ нь нэр дэвшигчдийн талаар мэдээлэл гаргахаас зайлсхийж байв. Харин нэвтрүүлгийнхээ 36 орчим хувийг улс төртэй холбогдолтой засгийн газрын үйл ажиллагаанд, 22 орчим хувийг МАН-ын парламентын үйл ажиллагаанд буюу тус намын болон тэргүүлсэн Засгийн газрынх нь нийгмийн хөтөлбөр санаачилгуудад зориулж байлаа. АН болон тус намын нэр дэвшигчид МҮОНРТ-ийн нэвтрүүлгийн цагийн 4 хувь оногдсон байна. Түүнчлэн эдгээр нэвтрүүлгийн дийлэнх нь сөрөг өнгө аястай байжээ. Ерөнхийдөө сонгуулийн талаарх МҮОНРТ-ийн нэвтрүүлгүүд засгийн газарт үйлчилж байсныг харуулсан бөгөөд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хуулиар хүлээсэн үүрэгтэй нь зөрчилдөж байлаа.⁶¹

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны хэвлэл мэдээллийн мониторингоор арилжааны мэдээллийн хэрэгслүүдийн редакцийн бодлого хязгаарлагдмал буйг харуулсан ба энэ нь сонгогчдод нэр дэвшигчдийн талаар цогц мэдээллийг аль ч мэдээллийн хэрэгслээс авах боломж дулимаг байсныг харууллаа. Мониторинг хийсэн таван телевизээс *Ийгл ньюс* нь МАН болон тус намаас нэр дэвшигчийг илэрхий дэмжин, улс төрийн мэдээний нэвтрүүлгийнхээ 32 хувийг зориулж, ихэвчлэн эерэг өнгө аястай нэвтрүүлж байв. Харин АН болон тус намаас нэр дэвшигчид нэвтрүүлгийнхээ 20 хувийг зориулсан ч ихэвчлэн төвийг сахисан, эсвэл сөрөг өнгө аястай байлаа. Үүнтэй эсрэг дүр зураг *С1* телевиз дээр ажиглагдаж байсан ба нэр дэвшигчдийн талаарх улс төртэй холбогдолтой мэдээний нэвтрүүлгийнхээ 46 хувийг МАН, түүний нэр дэвшигчид зориулж, нэвтрүүлэг нь сөрөг өнгө аястай байжээ. *С1* телевиз нь нэвтрүүлгийнхээ 29 хувийг АН, түүний нэр дэвшигчид зориулж, ерөнхийдөө эерэг өнгө аястай нэвтрүүлж байв. Харин *TV5* болон *TV9* телевизийн мэдээний нэвтрүүлгүүд АН, МАН-ын талаар гэхээс илүү нэр дэвшигчдийн хурал цуглааныг нэвтрүүлэхээс гадна МАХН, түүний нэр дэвшигчид илэрхий илүү цагийг зориулж байжээ. Хоёр дахь санал хураалтын өмнө нэвтрүүлгийн редакцууд нь сонгуулийг эсэргүүцэж, хоосон саналын хуудас өгөхийг уриалсан хөдөлгөөнийг эсвэл дэмжиж, эсвэл буруушааж байсан нь арилжааны мэдээллийн хэрэгслүүдийн редакци аль нэг талыг баримталдаг гэдгийг онцлон харуулж байлаа.⁶²

⁶⁰ Тухайлбал, 5-р сарын 29-нд цацагдсан нэвтрүүлгээр шүүхээр гадуур цаазаар авахыг уриалсан. Уг нэвтрүүлгийг нэр бүхий нэр дэвшигчтэй холбоотой нэгэн аж ахуйн нэгж бэлтгэсэн байв.

⁶¹ Үндэсний олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 3.1-р болон 4.1 зүйлд МҮОНРТ нь олон нийтэд үйлчилнэ гэж заасан байдаг.

⁶² *С1* телевиз нь хоосон саналын хуудас өгөхийг уриалсан хөдөлгөөнийг эрс шүүмжилж байхад, *TV9* телевиз дэмжиж байлаа.

Эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дотор төлбөртэй сонгуулийн сурталчилгаа явуулахаас татгалзан, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрүүдэд өдөр тутам харьцуулсан дүн шинжилгээ хийсэн нэвтрүүлэг бэлтгэж, нэр дэвшигчдийн талаар мэдээллээ тэнцвэртэй цацаж байснаараа *Монгол TV* телевиз илэрхий ялгарч байлаа. Хоёр дахь шатны санал хураалтын өмнө *Монгол TV* телевиз хоёр нэр дэвшигчид нэвтрүүлгийн цагаа адил тэнцүү хуваарилж өгчээ.

МҮОНРТ нь 6 дугаар сарын 24-ний өдөр гурван нэр дэвшигчийг оролцуулж, шууд мэтгэлцээнийг зохион байгуулсан. Гэвч мэтгэлцээн дээр нэр дэвшигчдийн дунд шууд харилцаа үүсээгүй бөгөөд мэтгэлцээн болсон студид үзэгч сонсогчид байгаагүй. МАН-ын нэр дэвшигчид хандан сонгосон асуултууд өөрийг нь болон гэр бүлийг нь магтан сайшаасан агуулгатай байсан бол, АН болон МАХН-ын нэр дэвшигчдэд сонгосон асуултууд нь сонгуулийн сурталчилгааны үеэр тэдний эсрэг гарч байсан асуудлуудыг хөндсөн. Мэтгэлцээн зохион байгуулах санаачилга хувийн хэвшлийн телевизүүдээс гарч байсан боловч нэр дэвшигчид мэтгэлцээн болох газар, ямар хэлбэрээр мэтгэлцэх тал дээр тохирч чадаагүй тул бүтээгүй. Хоёр дахь санал хураалтын өмнө нэр дэвшигчдийн дунд ийм шууд мэтгэлцээн хийгдсэнгүй.

Хэвлэмэл мэдээллийн хэрэгслүүдийн редакцийн бодлогод хараат бус, дүн шинжилгээнд суурилсан агуулга мөн л дутагдаж байлаа. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ноос мониторинг хийсэн сонингуудын хоёр нь тодорхой нэг намыг дэмжсэн бол, нэг сонин нь зөвхөн хоёр улс төрийн намын талаар л мэдээлэл гаргаж байлаа.⁶³ Сонгуулийн сурталчилгаа явуулах талаар хэвлэмэл мэдээллийн хэрэгсэлд хүлээх хуулийн тусгайлсан үүрэг харицулага байдаггүй ажээ.

Төлбөртэй сонгуулийн сурталчилгааны цаг нь сонгуультай холбоотой мэдээлэлд оногдох ёстой хязгаараас давж байсан бөгөөд оргил цагийн нэвтрүүлгийн 56 хувийг дунджаар эзэлж байлаа. Ийм нэвтрүүлгүүд нь сонгуулийн сурталчилгаанаас ирүүлсэн мэдээллийн хэсгүүд (56 хувь), сурталчилгааны хэсгүүд (21 хувь), өрсөлдөгчдөө шүүмжилсэн хэсгүүд (23 хувь)-ээс бүрдэж байв. Хоёр дахь санал хураалтын өмнө эдгээр төлбөртэй улс төрийн сурталчилгаа нь МАН, эсвэл АН-ын нэр дэвшигчийн үзэл бодол болон амжилтуудыг нь сурталчилсан аястай мэдээ, мэдээллийн нэвтрүүлгээр солигджээ.⁶⁴ Нэвтрүүлгийн үеэр хийгдэж байсан мэдэгдлүүдэд редакцийн зүгээс үнэлэлт дүгнэлт хийгээгүй.

Жендэртэй холбоотой асуудлууд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн хэлэлцүүлэгт огт хөндөгдөөгүй. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны хэвлэл мэдээллийн мониторингоор хэвлэл мэдээллийн хэрэгслүүд эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцооны асуудлыг хөндсөн сэдэвт-хэлэлцүүлэг, эсвэл цаг үеийн мэдээ мэдээллийн ямар ч нэвтрүүлэг хийгээгүй нь харагдсан.

ХП. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Монгол Улс нь Хөгжлийн бэршээлтэй ирэгдийг эрхийг хамгаалах тухай НҮБ-ын конвенцид 2009 оноос нэгдэн орсон. Үндсэн хуулиндаа ялгаварлан гадуурхаж үл болно гэсэн ерөнхий зарчмыг тусгасан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухайд тусгайлан заалт байдаггүй. Харин СТХ, 2006 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор улс төрд оролцох эрхийг нь баталгаажуулжээ. Гэвч эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон сонгогчдын санал өгөх эрхийг хязгаарлаж буй нь сэтгэцийн болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн иргэний болон сонгуулийг эрхийг нь хасаж байна.

АН болон МАН-аас дэвшиж буй нэр дэвшигчид хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, амьдралын чанарын талаар тусгасан бол, МАХН-ын нэр дэвшигч уг асуудлыг огт

⁶³ Өнөөдөр болон Үнэн сонингууд МАН-ыг, Зууны мэдээ сонин – МАХН-ыг, харин Өдрийн сонин гол төлөв МАН болон АН-ын тухай хэвлэн нийтэлж байлаа.

⁶⁴ Хоёр дахь санал хураалтын хоорондох хугацаанд эдгээр нэвтрүүлгүүд нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн оргил цагийн 31 хувийг эзэлж байв.

хөндөөгүй. Олон нийтийн радио телевиз сонгуулийн сурталчилгааны мэдээг дохионы хэлээр хүргэж байснаас гадна зарим нэр дэвшигчид сурталчилгааны мэдээлэлдээ дохионы хэл ашиглажээ. Үүний сацуу зарим нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны цуглаан, хурал болон сурталчилгааны нэвтрүүлгээр дохионы хэл ашиглаж байлаа. СЕХ нь Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)-тай хамтран харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан сонгогчдын боловсролд чиглэсэн сонгуулийн материалуудыг гаргаж, мөн хоёр санал хураалтын сонгуулийн сурталчилгааны үеэр сонгогчдод зориулсан видео бичлэгтээ дохионы хэлийг нэмж оруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн дагуу СТХ-иар хөгжлийн бэрхшээлтэй сонгогч нь өөрийн сонгосон хүнээр туслуулан саналын хуудсыг тэмдэглүүлж болно.⁶⁵ Түүнчлэн санал авах байруудад харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгаж, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг заасан байдаг. Сонгуулийн хоёр санал хураалтын үеэр ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчдын тэмдэглэснээр зөөврийн бүтүүмжилсэн санал авах хайрцгаар санал өгөх үйл явцад болон очиж ажигласан санал авах байруудад энэ заалтуудыг дагаж мөрдөж байжээ. Хэдийгээр СТХ-иар санал авах байрууд нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл боломжоор хангагдсан байх ёстой гэж заасан боловч ихэнх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орох боломжгүй байшин барилга дотор байрлаж байв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагуудын тооцоолсноор хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын 90 хүртэлх хувь нь санал авах байранд очиж саналаа өгөхийн оронд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөхийг илүүд үздэг ажээ. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөөврийн хайрцгаар саналаа өгөх боломжийг олгож буй нь иргэний болон сонгуулийн эрхийг нь хангаж байгаа ч, зарим тохиолдолд үүнийгээ санал авах байрыг тэдэнд орох боломжтой болгож чадаагүй шалтгаанаа тайлбарлахад ашиглаж байсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуулийн үйл явцад бусад иргэдтэй адил оролцох нөхцөлийг бүрдүүлсэнгүй.⁶⁶

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд ижил тэгш оролцох эрхийг хангахын тулд санал авах байруудад тэргэнцэртэй сонгогчид орох нөхцөлийг сайжруулахад СЕХ цаашид анхаарах нь зүйтэй.

ХШ. ИРГЭНИЙ БА ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД

Дотоод, гадаадын болон олон улсын байгууллагууд, мөн нэр дэвшигчээ дэвшүүлж буй намууд сонгуулийн ажиглагч томилж болно. Дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах, ажиглалтын тайлангаа хэвлэн нийтлэх болон саналын хуудасны зурган ба тоон үзүүлэлтийг цахим хэлбэрээр хуулбарлан авах гэх зэргээр ажиглагчдад холбогдох эрхийг хангалттай хэмжээнд олгосон байдаг.

СЕХ нь Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээний гишүүн зургаан төрийн бус байгууллага (ТББ)-ыг бүртгэсэн.⁶⁷ Нэмж хоёр ТББ бүртгүүлэх хүсэлт гаргасан ч, СЕХ бүртгэхээс татгалзжээ.⁶⁸ СЕХ нь нэр дэвшигч дэвшүүлсэн улс төрийн намуудын анхан шатны

⁶⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци нь “хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид өөрийн сонгосон хүнээр туслуулан саналын хуудсыг тэмдэглүүлэх эрхийг нь хангах ёстой” гэж заажээ.

⁶⁶ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 29-р зүйлд улс орнуудад “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн үйл хэргийг хэрэгжүүлэхэд ялгаварлан гадуурхалгүйгээр бусадтай адил тэгш нөхцөлд үр ашигтай, бүрэн оролцох орчин нөхцөлийг идэвхтэйгээр сурталчилж, нийтийн үйл хэрэгт тэдний оролцоог урамшуулах”-ыг зөвлөсөн байдаг. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгуульд оролцох тухай Сонгуультай холбоотой Сайн туршлагын дүрмийн талаар тайлбарласан Венецийн комиссын шинэчилсэн тунхаглал-ыг үзнэ үү.

⁶⁷ Сүлжээний гишүүн байгууллагууд нь: Нээлттэй нийгэм форум, Глоб интернэшнл, МИДАС, Өөрчлөлтийн төлөөх Эмэгтэйчүүд ТББ, Захиргааны шинэ санаачлаг болон Бодлогод залуусын хяналт ТББ-аас бүрдэж байна.

⁶⁸ Тухайлбал, нэг ИНБ сонгууль ажиглах хүсэлт СЕХ-д хүргүүлсэн боловч байгууллагынхаа санхүүжилтийн талаар нэмэлт мэдээлэл ирүүлэх шаардлагыг биелүүлж чадаагүй байна. Хоёр дахь санал хураалтын

санал хураалтыг ажиглах 17,947 ажиглагчийг, мөн хоёр дахь санал хураалтыг ажиглах АН болон МАН-ын 14,242 ажиглагчийг тус тус бүртгэж, үнэмлэх олгожээ. Хоёр дахь санал хураалтын өмнө байгууллагууд СЕХ-нд дахин бүртгүүлэх шаардлагагүй байсан хэдий ч ажиглагчид нь ажиглалт хийх СХХ-дод дахин бүртгүүлэх ёстой байв.

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналтын сүлжээ нь хэвлэл мэдээлэл, сонгуулийн сурталчилгааны зардал болон санал тоолох электрон төхөөрөмжийн бэлтгэл ажилд мониторинг хийсэн. Тус сүлжээ нь сонгуулийн анхан шатны санал хураалт болохын өмнөхөн санал тоолох төхөөрөмж болон СЕХ-ны сервер дээр нэмэлт, хараат бус хяналт шалгалтыг мөн явуулсан. Энэхүү сүлжээний гишүүн байгууллагууд нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийн нөлөөлөлд автсан тухай, сонгуулийн сурталчилгааны зардал ил тод бус, саналын машины үнэн зөв, аюулгүй байдал, СЕХ-ны серверийн талаар онцлон тэмдэглэсэн мэдээллийг тогтмол гаргаж байсан. Хэдийгээр хоёр санал хураалтын өдрүүдэд ИНБ-ууд нарийвчилсан байдлаар ажиглалт хийгээгүй ч, сонгуулийн үйл ажиллагааны талаарх чухал асуудлуудад олон нийтийн анхаарлыг хандуулж, хараат бус мэдээллээр сонгогчдыг хангаж өгөв. Нийслэл хотоос гадна үйл ажиллагаа явуулдаг ИНБ-ууд сонгуулийн үйл явцад мониторинг хийхэд төдийлөн идэвхтэй оролцсонгүй. Цөөн тооны ИНБ-ууд СЕХ-ны боловсруулсан гарын авлагыг ашиглаж, сонгогчдын боловсролд чиглэсэн хөтөлбөрүүдэд хувь нэмрээ оруулжээ.

Иргэний нийгмийн сүлжээ нь сонгуулийн эхний санал хураалтын өдөр Улаанбаатар хотод 100 ажиглагч, харин хоёр дахь санал хураалтын өдөр 40 ажиглагч тус тус ажиллуулжээ. Сонгуулийг хуулинд нийцүүлэн зохион байгуулсныг ажиглагчид онцолж байв. Гэсэн хэдий ч сүлжээний ажиглагчид хэд хэдэн зөрчил тэмдэглэсний дотор сонгогчид саналын хуудсыг тэмдэглэхэд асуудалтай тулгарч байсан, зарим СХХ-д ажиглагчдад мэдээлэл өгөхөөс цааргалах, тэргэнцэртэй сонгогчдод санал авах байранд орох нөхцөл боломжоор хангаагүй зэрэг асуудлууд байв. Тус сүлжээ нь хоёр дахь шатны санал хураалтын талаар ямар нэг мэдэгдэл гаргаагүй болно.

XIV. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ

Иргэн, хуулийн этгээд нь сонгуулийн үйл явцад хамаарах аливаа шийдвэр, үйл ажиллагааны талаар өргөдөл гомдол гаргах эрхтэй байдаг. Сонгуулийн хороодын үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй)-ны улмаас эрх нь зөрчигдсөн гэж үзвэл өргөдлөө тухайн сонгуулийн хороонд гаргаж, гаргасан шийдвэрээ дээд шатны хороонд давж заалдах боломжтой. СЕХ-ны шийдвэрийг эхлээд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар гаргах ба цаашлаад Дээд шүүхэд хандана. СЕХ-ноос гарч буй шийдвэрүүд, үүний дотор сонгуулийн дүнтэй холбогдуулан Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэж болдог.

Нэхэмжлэл гаргагч нь сонгуулийн байгууллагын маргаантай шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор нэхэмжлэл гаргах эрхтэй. Захиргааны хэргийн шүүх 40 хоногийн хугацаанд, Дээд шүүх нь 21 хоногийн хугацаанд сонгуультай холбоотой хэргүүд дээр шийдвэр гаргана. Үндсэн хуулийн цэцэд шийдвэр гаргахтай холбоотой тодорхой заасан эцсийн хугацаа байдаггүй. Сонгуулийн сурталчилгааны үеэр захиргааны ба эрүүгийн хэргүүдийг эхлээд цагдаагийн газраас шалгаж тогтоогоод, доод шатны шүүхээр хянан шалгуулдаг. Сонгуультай холбоотой хэргүүдийг шалгаж тогтоох, шийдвэр гаргахтай холбоотой тодорхой заасан хугацаа хууль тогтоомжид алга байна.

Шийдвэр гаргах эцсийн хугацаа нь хэтэрхий урт, сонгуулийн хуанлитай зөрчилдөж, хуулиар хамгаалуулах эрхийг хязгаарлаж байгаа явдал нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт

бичиг болон олон улсын сайн туршлагатай нийцэхгүй байна.⁶⁹ Нөгөөтэйгүүр, хугацаатай холбоотой зөрчилдөөн нь сонгуулийн дүнг эргэлзээтэй болгоход хүргэж байна. Мөн шүүхийн шийдвэр гарах хугацаа нь ч Үндсэн хуулийн заалттай зөрчилдөж байна. Учир нь ерөнхийлөгчөөр сонгогдсон нэр дэвшигч нь давж заалдах хугацаа дуусаагүй байхад тангаргаа өргөх ёстой байдаг.⁷⁰

Сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх хугацааг үндэслэлтэй болгож, сонгуулийн хуанлитай уялдуулах нь зүйтэй.

СЕХ нь нийтдээ 63 өргөдөл гомдлыг иргэд, улс төрийн намууд болон ИНБ-даас хүлээн авснаас 40 орчим нь сонгуулийн эхний санал хураалтын өмнө, үлдсэнийг нь хоёр санал хураалтын хооронд авчээ. Хоёр дахь санал хураалтын дараа сонгуультай холбоотой өргөдөл, гомдол СЕХ-нд ирүүлсэн талаар мэдээлэл ирээгүй. Эдгээр өргөдөл, гомдлын 24-ийг АН болон тус намын нэр дэвшигчийн сонгуулийн штабаас ирүүлжээ. МАХН-аас зургаан өргөдөл, гомдол гаргасан бол МАН-аас дөрвийг гаргажээ.

Өргөдөл, гомдлуудын дийлэнх нь нэр дэвшигч ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх шаардлага хангаж байгаа эсэх, сонгогчдын нэрийн жагсаалт болон сонгуулийн сурталчилгааны журам зөрчсөнтэй холбоотой байлаа.⁷¹ Нэр дэвшигчид тавих шаардлага хангаж буй эсэхтэй холбоотой ирүүлж байсан өргөдөл, гомдлуудыг СЕХ өөрийн эрх мэдлээс хэтэрсэн гэх үндэслэлээр буцааж байв. Хэдийгээр процедурын алдаа дутагдалтай байсан хэдий ч СЕХ нь өргөдөл, гомдлыг ерөнхийдөө цаг тухайд нь шийдвэрлэсэн.⁷² СЕХ-оос өргөдөл, гомдлын талаар гаргаж байсан шийдвэрүүдэд хуулийн бүрэн үндэслэл дулимаг байсан бөгөөд СЕХ-ны цахим хуудас дээр байршуулаагүй. Зөвхөн МАХН-ын анхны нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан СЕХ-ны шийдвэрийг л шүүхээр хэлэлцсэн байна.

АНСХ болон СДСХ-дтой холбогдох хэд хэдэн гомдол гарсан нь ихэнхдээ сонгуулийн байгууллагын бүрэлдэхүүн, санал авах байрны байршил болон сонгуулийн сурталчилгааны зохицуулалттай холбоотой байв. СЕХ нь доод шатны сонгуулийн хороодод гаргасан өргөдөл, гомдлын талаар нэгдсэн жагсаалт үйлдээгүй бөгөөд өргөдөл, гомдлын нийт тоо, агуулга болон хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл нь олон нийтэд нийтлэгдээгүй. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны хөдөө орон нутагт уулзаж ярилцсан хүмүүс сонгуулийн доод, дунд шатны байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдол шийдвэрлэж буй үйл явцад ил тод байдал дутагдаж, хуульд нийцэхгүй гэх албан ёсны гомдол харьцангуй цөөн байсан талаар дурдаж байлаа.

Анхан шатны санал авах өдрөөс өмнө цагдаагийн байгууллагад сонгуулийн сурталчилгаатай холбоотой 500 орчим гомдол ирснээс зурагт самбарыг сүйтгэсэн, нэр дэвшигчдийг гутаан доромжилсон, мөн санал худалдан авах гэж байна гэсэн гомдлууд иржээ.⁷³ Анхан шатны сонгуулийн санал авах өдөр цагдаагийн байгууллагад нийт 150 гаруй гомдол ирснээс 86 нь санал худалдан авах тухай гомдлууд байжээ. Үүний зэрэгцээ хоёр санал хураалтын хоорондох хугацаанд сонгогчдод мөнгөн урамшуулал хууль бусаар тарааж байна гэх гомдлуудын тоо эрс

⁶⁹ ЕАБХАБ-ын 1990 оны Копенхагены баримт бичгийн 5.10-р зүйлд “үндсэн суурь эрхийг хүндэтгэж, хууль эрх зүйн шударга байдлыг хангах үүднээс хүн бүр захиргааны гаргасан шийдвэрийг эсэргүүцэн барагдуулах үр дүнтэй арга хэрэгслийг авах эрхтэй байна” гэж заажээ. Мөн “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 2.3-р зүйлд “улс орнууд ... ийнхүү хүлээн зөвшөөрөгдсөн эрх нь зөрчигдсөн хүн хуулиар хамгаалуулах эрхийг хангах үүрэгтэй” гэжээ.

⁷⁰ ҮХ-ийн 32.2-р зүйлд “Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор тангараг өргөнө” гэж заажээ.

⁷¹ Эдгээрт мэдээлэл, тодруулга хүссэн, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгосон болон сонгуулийн өдөр санал авах үйл ажиллагааны талаар заварчилга хүссэн хүсэлтүүд мөн байжээ.

⁷² Тухайлбал СЕХ-нд ирсэн гомдлын гурвыг нь тус хорооноос цагдаагийн байгууллагад шилжүүлжээ. Гэвч зарим тохиолдолд СЕХ нь өргөдөл гаргагчдыг шууд цагдаагийн байгууллагад хандахыг зөвлөж байлаа.

⁷³ Анхан шатны санал хураалтын өмнөхөн эдгээр хэргийн 65 хувийг нь шүүхийн байгууллагад шилжүүлсэн, эсвэл хэрэгсэхгүйд тооцжээ.

нэмэгдэжээ.⁷⁴ Гэвч цагдаагийн байгууллага нь анхан шатны санал хураалтын өмнө гаргаж байсан шигээ сонгуультай холбоотой ирсэн гомдлуудын тоо, шийдвэрлэсэн байдлын талаар нэгтгэсэн мэдээлэл гаргаагүй. Гомдол гаргагчдын дийлэнх нь санал худалдан авах гэсэн үйлдлийн талаар хангалттай баримт нотолгоогүй байсныг ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд хүлээн зөвшөөрчээ.

Сонгуулийн эхний санал хураалтын өмнөхөн МАХН-ын зүгээс тус намын нэр дэвшигчийг айлган сүрдүүлсэн гэх гомдол гаргасан.⁷⁵ Хэргийг Тагнуулын ерөнхий газарт шилжүүлсэн бөгөөд сонгуулийн дараагаар ч ун хэрэг мөрдөн байцаалтын шатанд байлаа.

Энэ тайланд тэмдэглэсэнчлэн, хууль бус санхүүгийн ажиллагаатай холбоотой цагдаагийн байгууллагад ирсэн хоёр томоохон хэрэг сонгуулийн өмнөх орчинд нөлөөлсөн. Хуулиар хориглосон байдаг ч гадаадын шашны байгууллагаас сонгуулийн сурталчилгааны хандив авсан гэх үндэслэлээр нэгэн иргэн СЕХ-нд гомдол гаргаснаар МАХН-аас нэр дэвшигчийн нэр дэвших эрх нь сонгууль болохоос хэдхэн хоногийн өмнө хөндөгдөв.⁷⁶ Зургаадугаар сарын 23-ны өдөр цагдаагийн байгууллага 1.08 тэрбум төгрөгийн бэлэн мөнгийг хураан авсан өөр нэг хэрэг гарсан ба энэ мөнгөөр АН-ын нэрийн өмнөөс сонгогчдыг хахуульдах гэж байсан тухай цагдаагийн газраас мэдээлсэн. Энэхүү хоёр хэргийг цагдаагийн газар шуурхай зохицуулсан ч, сонгууль болохоос өмнө ямар нэг шийдвэр гарсангүй. АН болон МАХН-аас ажиглагчидтай уулзаж ярилцсан хүмүүс цагдаагийн байгууллага эдгээр хэргийн талаар олон нийтэд мэдэгдсэнд санаа зовниж буйгаа илэрхийлж байсан бөгөөд МАХН-тай холбоотой хэрэг дээр шүүхээр нотлогдоогүй байхад СЕХ нэр дэвшигчид нь шударга бус хандсан гэж байв.

Анхан шатны санал хураалтын дараа МАХН-аас сонгогчдын ирцийн тоо зөрсөн гэх үндэслэлээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандан сонгуулийн дүнг хүчингүй болгох тухай гомдол гаргасан. Долдугаар сарын 5-ны өдөр тус шүүхээс өргөдлийг буцаах шийдвэр гаргав. МАХН-аас УИХ-ыг тараах тухай өргөдлийг СЕХ-нд мөн гаргасан боловч энэхүү өргөдөлд шууд хариу өгөөгүй.

XV. СОНГУУЛИЙН ӨДӨР (АНХАН ШАТ)

Сонгуулийн ажиглалт хийх аргачлалын дагуу ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ нь сонгуулийн өдрийн үйл явцад нэг бүрчлэн дэлгэрэнгүй ажиглалт хийгээгүй болно. Сонгуулийн өдөр тус хорооны очиж ажиглалт хийсэн хэсгийн хороодод сонгууль дэг журамтай явагдаж өнгөрлөө. Сонгуулийн хэсгийн хороодын ажилтнууд санал хураалтыг тогтоосон журмын дагуу зохион байгуулав. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны очиж ажигласан доод шатны сонгуулийн хороодод эмэгтэй ажилтнууд давамгайлж байв. Тус хорооны очиж ажигласан бүх сонгуулийн хороодод улс төрийн намуудын ажиглагчид ажиллаж байсан, харин иргэний нийгмийн ажиглагчидтай зөвхөн нийслэл хотод л таарч байлаа.⁷⁷

Санал авах өдрийн өмнөх өдөр ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчид нийт найман аймагт болон нийслэл Улаанбаатар хотод зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах

⁷⁴ Нийслэлийн цагдаагийн газраас санал худалдан авах гэсэн 60 гаруй гомдол ирсэн гэж ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ-нд мэдээлжээ.

⁷⁵ Зургаадугаар сарын 6-нд МАХН-ын нэр дэвшигчийн гэрт нь дотор нь гурван сум хийсэн хайрцагтай илгээмж иржээ.

⁷⁶ Уг гомдлыг дүрс бичлэгт үндэслэн СЕХ-нд 6-р сарын 21-нд ирүүлжээ. Цагдаагийн байгууллагаас мөн өдөр дүрс бичлэг нь үнэн болохыг нотолж, Баянзүрх дүүргийн шүүхэд шилжүүлжээ (гэвч нэр дэвшигчээс мэдүүлэг аваагүй). Дараа өдрийнх нь өглөө шүүх эл хэргийг цагдаагийн байгууллагад нэмэлт мөрдөн байцаалтад шилжүүлсэн байна.

⁷⁷ Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээнээс Улаанбаатар хотын 6 дүүргийн 50 саналын хэсэгт ажиглагчид ажиллуулжээ.

ажиллагаанд оролцов.⁷⁸ Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа ерөнхийдөө журмын дагуу явагдсан боловч саналын нууцлал алдагдах байдал мэр сэр ажиглагдлаа.

А. Санал өгөх ба санал тоолох үйл явц

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны очиж ажигласан санал авах байруудын нээлт дээр ямар нэг ноцтой саатал гарсан тухай мэдэгдээгүй бөгөөд шаардлагатай бүх материал, эд хэрэгсэл байсан. СТТ-тэй холбоотой ямар нэгэн ноцтой зөрчил гарсан гэж мэдэгдээгүй. ЕАБХАБ/АИХЭГ-аас өмнө өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн сонгогчдод саналаа нууцаар өгөхөд зориулсан нууцлалын хавтас өгсөн нь сайшаалтай. Гэвч олон улсын ажиглагчдын хэлснээр уг хавтасыг хэрэглэх талаар сонгуулийн ажилтнууд болон сонгогчид тэр бүр ойлгохгүй байлаа. Үүний улмаас саналын нууцлал зарим үед алдагдаж байлаа.

Зургаадугаар сарын 23-ны өдөр АН-аас ирүүлсэн шаардлагын хариуд СЕХ нь сонгогчдод хурууны тусгай тэмдэглэгээг, гэхдээ зөвхөн Улаанбаатар хотын сонгуулийн хэсгүүд дээр хийх шийдвэрийг гаргасан. Дээрх сонгогчдод хурууны тэмдэглэгээ хийх талаар СЕХ-ноос СХХ-дод сүүлийн мөчид хүргүүлсэн зааварчилгаа ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны очиж ажигласан санал авах байруудад тогтмол хэрэгжиж байв. Гэвч сонгогчийн биометрийн өгөгдөхүүн мэдээллийг шалгаж тулгасан нөхцөлд сонгогчдод хурууны тэмдэглэгээ хийх нь илүү ажил боллоо. Түүнчлэн дахин санал өгөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхой бүлэг сонгогчдод хамаатуулах нь бас асуудал дагуулсан үйлдэл байв. Үүнээс үүдэн дээрх арга хэмжээ нь сонгуульд нэгэнт ашиглаж буй технологид итгэх итгэлийг бүрхэгдүүлэхэд хүргэж байна.⁷⁹

В. Сонгуулийн дүнг нэгтгэж, зарлах үйл явц

Санал авах ажиллагаа дуусмагц санал авах байрууд СТТ-г унтрааж, төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудсыг болон санал хураалтын үр дүнгийн мэдээллийг СЕХ руу тэр даруйд нь хамгаалалттай сүлжээгээр цахимаар дамжуулж байв. СТХ-иар санал хураалт дууссаны дараа СДСХ санамсаргүй сонголтын аргаар харьяа хэсгийн хорооноос 50 хүртэлх хувийг сонгож тооллого хийнэ гэж заасан хэдий ч АН-ын шаардлагын дагуу 6 дугаар сарын 23-ны өдрийн СЕХ-ны шийдвэрээр хуульд заасан хамгийн дээд хувь руу ойртуулан, улс даяар санал авах байрны 50 орчим хувийг санамсаргүй сонголтын аргаар сонгож, техникийн тооллогыг хийсэн. Ийм техникийн тооллого хийх шаардлагыг 2016 оны УИХ-ын сонгуулийн үеэр зарим СХХ-дод, тодруулбал тодорхой нэг санал авах хэсэг дээр хамгийн доод хувьд ойртуулан тооллого хийсэнтэй холбоотой гаргасан ажээ. Техникийн тооллого хийх, мөн дээр дурдсан хяналтын арга хэмжээ нь уг технологи нь үнэн зөв, найдвартай гэдгийг оролцогч талуудад харуулснаар санал тоолох төхөөрөмжид итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Гэвч нөгөө талаар ийнхүү нийт санал авах байрны тал хувьд тооллого хийсэн нь илүү ажил болохоос гадна сонгуулийн технологид оролцогч талуудын итгэх итгэлийг бууруулах магадлал өндөр байлаа. Техникийн тооллогоор гарсан дүн нь санал тоолох төхөөрөмжөөс гарсан тооллогын дүнг баталгаажуулжээ. Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох ажиллагааг санал авах шөнө санал хураалт дуусмагц СЕХ-ны байран дээр ажиглагчдыг байлцуулан явуулсан.

СЕХ нь санал хураалтын урьдчилсан дүнг СХХ-доос шөнийн турш дараагийн өдрийн өглөө хүртэл хүлээн авч байв. Сүлжээ тасарсан болон сүлжээний шугамд техникийн саатал гарч, хөдөө орон нутгийн зарим СХХ-дод санал хураалтын урьдчилсан дүнг шууд дамжуулахад саад

⁷⁸ Тухайлбал, анхан шатны санал хураалтад нийтдээ 28,045 сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөх хүсэлтээ ирүүлжээ.

⁷⁹ ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ-ны ажиглалт хийсэн АНСХ болон СДСХ-дод иргэний бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчдын бүртгэлтэй хурууны хээгээр шалгахад ямар нэгэн ноцтой зөрчил гараагүй.

учирчээ.⁸⁰ Мөн Баян-Өлгий аймагт сонгуулийн урьдчилсан дүнг шууд дамжуулалгүй СТХ болон СЕХ-ны журам дүрмийг зөрчиж, зарим СХХ-д техникийн тооллогыг хийсний дараа мэдээллээ дамжуулсан зөрчлүүд гарчээ. СЕХ-ноос тайлбарласнаар СХХ-д нь цаг хугацаа хожих, мэдээлэл дамжуулах явдал чирэгдлийг хэмнэх үүднээс ийнхүү саатсан гэжээ.⁸¹ Эдгээр саатал нь МАХН-ын зүгээс санал хураалтын дүнг будлиантуулсан гэх мэдэгдэл гаргах үндсийг тавьжээ.⁸² Энэхүү мэдэгдлийн хариуд СЕХ нь Баян-Өлгий аймагт санал хураалт явуулсан шөнө техникийн тооллогод хамрагдаагүй үлдсэн 47 СХХ-нд тооллого хийх шийдвэр гаргав. Энэхүү техникийн тооллогыг МАХН ажиглахаас татгалзсаныг онцлох нь зүйтэй. Техникийн тооллогын дүн нь сонгуулийн өдөр ирүүлсэн урьдчилсан дүнг баталгаажуулсан. Сонгуулийн ирцийн урьдчилсан мэдээллийг санал хууралт хийсэн өдрийн шөнө дундаас хойш зарласан бөгөөд 1,318,511 соногоч буюу 68.27 хувьтай гэж мэдэгдэв. Энэ дүн сонгуулийн нэгтгэсэн дүнг зарлах үед өөрчлөгдөж, 1,357,788 сонгогч буюу 68,27 хувь болжээ.⁸³

СЕХ нь санал хураалтын дүнг урьдчилсан байдлаар шууд дамжуулж байсан нь ил тод байдлыг ерөнхийд нь нэмэгдүүлж байв. Гэвч СЕХ-ны цахим хуудас дээр болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр санал хураалтын дүнг сум, хэсгийн хороодын аль нэгээр задаргаа хийж харуулаагүй нь бие даасан хяналт тавих боломжийг хязгаарласан явдал болов. СЕХ нь 6 дугаар сарын 30-ны өдрийн орой л сонгуулийн нэгтгэсэн дүнг цахим хуудсандаа байршуулсан ч зөвхөн аймгууд болон Улаанбаатар хотын есөн дүүргээр задаргааг хийж харуулжээ. Энэ нь бие даасан хяналт тавих боломжийг хязгаарласан явдал бөгөөд мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай олон улсын стандарттай нийцэхгүй байна.⁸⁴

Олон нийтэд өгч буй мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд СЕХ нь цаашид сонгуулийн өдөр сонгуулийн ирцийн тухай болон санал хураалтын урьдчилсан бүрэн дүнг хэсгийн хороодоор задаргаа хийж зарлах нь зүйтэй.

XVI. АНХАН ШАТНЫ СОНГУУЛИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

Анхан шатны санал хураалтын дүнгээр: АН-517,478 санал (38.11 хувь), МАН-411,748 санал (30.32 хувь) ба МАХН-409,899 санал (30.19 хувь) тус тус авч, нийт 18,663 сонгогч (1.37 хувь) саналын хуудсыг огт тэмдэглээгүй хоосон өгсөн байжээ. СЕХ-ноос анх зарласнаар 7-р сарын 9-нд явагдах ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь санал хураалтад АН болон МАН-ын нэр дэвшигчид оролцохоор тодорчээ. Сонгуулийн хоёр дахь санал хураалтын өдрийг наашлуулах олон тооны шаардлагыг хүлээн авсны дараа СЕХ нь шуурхай хуралдаж, ерөнхийлөгчийн ээлжит

⁸⁰ Тухайлбал, Говь-Алтай аймгийн Цогт суманд сүлжээний кабелийг санаатай тасалсаны улмаас хамгийн сүүлийн сонгуулийн хэсгээс дүнгийн мэдээллийг 6-р сарын 27-ны өглөөний 09.10 цагт хүлээн авчээ.

⁸¹ Хөдөө орон нутгийн сонгуулийн зарим хэсгүүд нь дүнгээ дамжуулахын тулд сүлжээтэй газарт очих, СДСХ-нд сонгуулийн материал хүргэх зэрэгт их хол газар явах шаардлага тулгарчээ. Иймд зарим СХХ-д цаг хугацаа хэмнэх үүднээс сонгуулийн үйл ажиллагааг бүрэн хийж гүйцэтгэсний дараа нэг мөр хүргүүлэхээр шийдвэрлэжээ.

⁸² Сонгуулийн шөнө МАХН-ын дэмжигчид санал хураалтын дүнг эсэргүүцэн СЕХ-нд хүчээр орохыг оролдож, хэсэг зуур төрийн хамгаалалтын ажилтнуудтай сөргөөцөлджээ.

⁸³ Сонгуулийн дүнг будилантуулсан гэх МАХН-ын мэдэгдлүүдэд ирцийн зөрүүтэй мэдээлэл мөн дурдагдаж байлаа. СЕХ-ноос ирцийн мэдээлэл зөрж буй шалтгааныг доод шатны сонгуулийн хороодоос ирцийн мэдээллийг утсаар авахдаа бүрэн гүйцэт аваагүйтэй холбон тайлбарлаж байлаа. Ирцийн нэгтгэсэн мэдээнд гадаад дахь сонгогчдын ирц орсон болно.

⁸⁴ Ерөнхий тайлбарын 34-р зүйлийн 19-р заалтад “ [...] гишүүн орнууд нь олон нийт сонирхож буй мэдээллийг ил тод зарлаж байх үүрэг хүлээнэ. Ийнхүү мэдээлэл авах эрхийг хангах бүхий л арга хэмжээг хангах үүрэгтэй” гэж заажээ. Ерөнхий тайлбарын 25-р зүйлийн 20-р зүйлийг үзнэ үү.

сонгуулийн хоёр дахь санал хураалтыг 7 дугаар сарын 7-ны өдөр явуулахаар зарлаж, санал хураалтын ажлыг зохион байгуулах хугацааг нэлээд шахжээ.⁸⁵

АН болон МАН нь сонгуулийн сурталчилгааны алдаа зөрчлийн талаар олон нийтэд зарлаж байсан хэдий ч сонгуулийн анхан шатны санал хураалтын дүнг хүлээн зөвшөөрөв. МАХН-ын зүгээс сонгуулийн хууль, журмыг зөрчсөн гэх олон тохиолдлыг дурдаж, сонгууль будлиантай явагдсан, санал хураалтын дүн хууль бус гэсэн мэдэгдэл гаргав. МАХН хоёр дахь санал хураалтад тодорсон хоёр нэр дэвшигчийн хэнийг нь ч хүлээн зөвшөөрөхөөс мөн татгалзаж байв. Анхан шатны санал хураалтын дүн нь хот-хөдөөгийн зааг ялгааг тод харууллаа: МАН болон МАХН нь хөдөө орон нутгийн сонгогчдын саналыг хувааж, харин АН нь нийслэл Улаанбаатар хотод дэмжигдэж, хотын сонгогчдын дунд илэрхий нөлөөтэй гэдгээ баталгаажуулав.

Хоёр санал хураалтын хооронд гарсан улс төрийн яриа хэлэлцүүлэг нь сонгогчдын ирц болон хоосон саналын хуудас өгөх асуудал дээр төвлөрч байлаа. Сонгогчдын ирцийн асуудал нь хурцаар тавигдаж байсан шалтгаан нь сонгогчдын тавин хувийн ирц бүрдээгүй тохиолдолд сонгууль хүчингүй болно гэсэн ташаа ойлголт олон нийтэд давамгайлж байсантай холбоотой байв.⁸⁶ АН-ын хувьд энэ тохиолдолд өөрийн нэр дэвшигчид нь хохиролтой гэж үзэж байлаа.

Хоосон саналын хуудас өгөхийг уриалж байсан хөдөлгөөн нь хоёр нэр дэвшигчийн аль нь ч хүчинтэй бүх саналын 50+1 хувийг авахаас сэргийлэх, улмаар сонгуулийг хүчингүй болгож, дахин сонгууль зарлах нөхцөлийг үүсгэх эсэргүүцлийн нэг арга болгон ашиглаж байлаа. Энэ санаачилга нь “Цагаан сонголт” уриалга дор нэлээд хүчийг авч, ялангуяа хотын залуу сонгогчдын мэдээллийн гол эх үүсвэр болох нийгмийн сүлжээнд ихээхэн түгсэн. Эл уриалгыг өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд шүүрэн авсны дотор *TV9* (МАХН-ыг дэмжигч), *Mongol TV* (төвийг сахисан), *Eagle News* (МАН-ыг дэмжигч) телевизүүд тодорхой хэмжээнд дэмжиж, харин *С1* (АН-ыг дэмжигч) телевиз эрс шүүмжлэн эсэргүүцэж байлаа. МАХН-аас нэр дэвшигч “Цагаан сонголт”-ыг 6 дугаар сарын 30-ны өдөр хийсэн хэвлэлийн бага хурал дээрээ ашигласан бол, МАХН-ын зүгээс уг санаачлагыг дэмжих тав хоногийн стратеги төлөвлөгөө боловсруулсан. Сайшаалтай нь, СЕХ-ны зүгээс хоосон саналын хуудсыг хууль бус үйлдэл гэдгийг зарлахыг хүссэн нэгэн өргөдлийн хариуд ийнхүү уриалах нь сонгогчдын хүсэл зоригийг чөлөөтэй илэрхийлэхийг хязгаарласан хөндлөнгөөс нөлөөлөх зорилготой, СТХ-иар хориотой үйлдэл болохыг мэдэгдэв.

XVII. СОНГУУЛИЙН ӨДӨР (ХОЁР ДАХЬ ШАТНЫ САНАЛ ХУРААЛТ)

A. Санал өгөх болон санал тоолох үйл явц

Хоёр дахь шатны санал хураалт авах өдөр сонгууль дэг журамтай явагдаж, санал хураалт тогтоосон журмын дагуу болж өнгөрлөө. СЕХ-ноос ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд өмнө нь санаа зовниж буйгаа илэрхийлж байсныг үл харгалзан сонгуулийн хэсгийн хороодод хангалттай тооны сонгуулийн болон улсын бүртгэлийн ажилтнууд, мөн бусад туслах ажилтнууд ажиллав. Сонгуулийн хороодод ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо эрчүүдийн тооноос мөн л давамгайлж байв. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны очиж ажигласан сонгуулийн хороодод МАН, АН-ын

⁸⁵ Хоёр дахь санал хураалтын өдрийг 7-р сарын 4-ны өдөр хүртэл наашлуулахыг (МАХН), АН болон түүнийг дэмжигч ИНБ-ын зүгээс 7-р сарын 6-ны өдөр болгохыг тус тус шаардаж байлаа. СЕХ-ноос санал хураалтыг наашлуулах шаардлагыг хүлээн зөвшөөрсөн шалтгаанаа тайлбарлаагүй ч, санал хураалтын ажлыг зохион байгуулах хугацааг харгалзан 7 дугаар сарын 7-ны өдөр явуулахаар шийдвэрлэсэн.

⁸⁶ 7-р сарын 3-нд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчид 11 аймаг болон Улаанбаатар хотын сонгуулийн албан тушаалтнууд болон улс төрийн намуудын 30 гаруй төлөөлөлтэй уулзаж, сонгогчдын тавин хувийн ирц бүрдээгүй тохиолдолд үйл явц хэрхэн өрнөх талаар тандалт хийсэн. Ихэнх нь дахин сонгууль явагдана гэсэн буруу ташаа ойлголттой байлаа.

ажиглагчид ажиллаж байсан бол, иргэний нийгмийн ажиглагчидтай зөвхөн нийслэл хотод л таарч байлаа.⁸⁷

Анхан шатны санал хураалттай харьцуулахад сонгогчдын ирц хоёр дахь шатны санал хураалт явагдсан эхний хэдэн цагт, ялангуяа Улаанбаатар хотоос гадуур мэдэгдэхүйц бага байлаа.⁸⁸ СХХ-дын ажилтнууд болон орон нутгийн захиргааны зүгээс сонгогчдыг саналаа идэвхтэй өгөхийг өдөөн дэмжсэн шийдэмгий боловч заримдаа сонгогчдын эрхэнд халдсан гэмээр алхмуудыг хийж байсан нь хэд хэдэн газар ажиглагдаж байлаа.⁸⁹ Түүнчлэн ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ нь сонгогчдыг автобусаар зөөсөн, мөн улс төрийн намуудын ажиглагчид сонгогчдыг дайчлахад идэвхтэй оролцож буйг харсан байна.⁹⁰

Сонгогчдод хурууны тусгай тэмдэглэгээ хийх зэрэг санал авах ажиллагааг ерөнхийдөө тогтоосон журмын дагуу мөрдөж байлаа. Анхан шатны санал хураалт дээр сонгогчдын хурууны хээгээр иргэний бүртгэлийн мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэлийг шалгах үйл явцад ямар нэгэн ноцтой зөрчил гараагүй. Мөн анхан шатны санал хураалтын үеэр саналын нууцлалын хавтасыг хэрэглэхэд сонгогчдод төөрөлдөл бага гарч байв. Хоёр дахь санал хураалтаас хэдхэн хоногийн өмнө СЕХ нь сонгогчдын хурууны хээгээр иргэний бүртгэлийн мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэлийг шалгасны дараа сонгогчийн бүртгэлийн хуудсыг нь хурааж авах зааварчилгааг СХХ-дод хүргүүлжээ.⁹¹ Ийнхүү сонгогчдын саналыг худалдан авах оролдлогыг бууруулах зорилготой сүүлийн мөчид гаргасан зааварчилгаа нь СХХ-дод цаг алдалгүй очин, мөрдөгдөж чадсан.

СТТ нь бараг нийт улсын хэмжээнд хэвийн ажилласан. Санал авах төрөөрөмжийг засах тохиолдол бараг гараагүй бөгөөд гэмтэл саатал гарсан цөөн тохиолдолд СЕХ-ны мэдээллийн технологийн багийн ажилтнууд шуурхай арга хэмжээ авч байлаа. Гэсэн хэдий ч, Төв аймгийн саналын хуудасны нууцлалын тусгай дугаар алдаатай хэвлэгдсэний улмаас СТТ танихгүй тохиолдолд гарчээ. Нөхцөл байдлыг залруулахын тулд СЕХ нь аймгийн нийт 84 хэсгийн хорооны СТТ-ийг цуглуулж, дахин програмчлав. Энэ хугацаанд санал хураалт хэвээр үргэлжилж байсан бөгөөд саналын хуудсыг саналын хайрцагны доор байрлах нэмэлт хайрцаг руу хийлгэж, СТТ-ийг дахин програмчилсны дараа төхөөрөмжид уншуулжээ.

В. Сонгуулийн дүнг нэгтгэж, зарлах үйл явц

Санал авах ажиллагаа дуусмагц санал хураалтын үр дүнгийн мэдээллийг тэр даруйд нь хамгаалалттай сүлжээгээр СЕХ руу дамжуулж байв. Анхан шатны санал хураалтын дараахтай адилаар санал авах байрны тал орчим хувийг санамсаргүй сонголтын аргаар сонгож, техникийн тооллогыг хийсэн. СЕХ нь Төв аймгийн бүх санал авах байранд техникийн толлого хийх шийдвэр гаргасан бөгөөд техникийн тооллогоор гарсан дүн нь санал тоолох төхөөрөмжөөс гарсан тооллогын дүнг баталгаажуулжээ. Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох

⁸⁷ Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээнээс Улаанбаатар хотын 20 хэсгийн хороонд ажиглагчид ажиллуулжээ.

⁸⁸ Баян-Өлгий аймгаас бусад 21 аймагт сонгогчдын ирц муу байжээ.

⁸⁹ Тухайлбал, Улаанбаатар хотод СХХ-д нь хорооны засаг дарга нартаа мэдээлж, тэдгээр нь иргэдэд шууд хандан уриалж байлаа. Цэцэрлэг хотод засаг дарга нь машинаас чанга яригчаар сонгогчдыг сонгуульд идэвхтэй оролцохыг уриалж байсан бол, Дархан хотын АНСХ, Өмнөговь аймгийн СХХ мөн үүнтэй ижил аргаар сонгогчдыг уриалжээ. Хэнтий болон Дарханд СХХ-дын гишүүд сонгогчид руу утасдаж, сонгуульд идэвхтэй ороцохыг уриалжээ.

⁹⁰ Улс төрийн намуудын ажиглагчид мөн сонгуулийн ирцийн талаар тогтмол мэдээлж, сонгогчдыг дахин уриалах шаардлагатай эсэхийг нягталж байв. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчид Баян-Өлгий болон Баянхонгор аймгуудад сонгуулийн хоёр санал хураалтын үеэр сонгогчдыг автобусаар зөөж ирэхийг ажиглажээ.

⁹¹ Анхан шатны санал хураалтын үеэр сонгогчдын бүртгэлийн хуудасны нэг хувийг сонгогчид өгч байв. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны уулзаж ярилцсан зарим хүмүүс сонгогчдын гар дээр очиж буй бүртгэлийн хуудасны энэ хувийг санал худалдан авах башир аргад ашигладаг гэж байлаа.

ажиллагааг СЕХ-ны байран дээр явуулсан. Гэвч энэхүү санал тоолох ажиллагаа нь зарим улсаас саналын хуудсууд ирж амжаагүй тул хоёр хоногоор хойшлов.

Санал хураалтын дүнг анхан шатны санал хураалтын үед мөрдөж байсны дагуу урьдчилсан байдлаар шууд дамжуулж байв. СЕХ нь санал хураалтын дүнг санал авах ажиллагаа дуусмагц телевизээр шууд дамжуулж байсан хэдий ч хэсгийн хороод тус бүрээр задаргаа хийгдэж гараагүйгээс гадна СЕХ-ны цахим хуудас дээр болон албан ёсны өөр ямар нэгэн цахим хуудсаар мэдээлээгүй нь олон нийтийн зүгээс сонгуулийн үр дүнд бие даасан хяналт тавих боломжийг хязгаарласан явдал болов. Сонгуулийн ирц 60.67 хувьтай гэж мэдэгдэв.

XVIII. СОНГУУЛИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

Санал хураалтын албан ёсны нэгтгэсэн дүнг 7-р сарын 9-ны өдөр СЕХ-ны цахим хуудаст байршуулав. Санал хураалтын дүнгээр АН-ын нэр дэвшигч 611,255 санал (50.61 хувь), МАН-ын нэр дэвшигч 497,067 санал (41.16 хувь) тус тус авсан бол, хоосон саналын хуудас өгсөн сонгогчдын тоо мэдэгдэхүйц нэмэгдэж 99,444 сонгогч (8.23 хувь) байв. АН-ын нэр дэвшигч олонхын санал буюу 50 хувийн босгыг хангасан учир сонгуульд ялсныг нь баталгаажуулав. АН-ын нэр дэвшигч санал хураалтын дүнг 7-р сарын 8-ны өглөө эрт хүлээн зөвшөөрөв. МАН-ын нэр дэвшигч мөн өдрийн үдээс хойно ялагдлаа хүлээн зөвшөөрсөн.

Хоёр дахь шатны санал хураалтын дүн нь анхан шатны санал хураалтын дүнтэй зэрэгцэж байлаа. АН нь хоёр дүүргийг эс тооцвол нийслэл Улаанбаатар хотыг дагуулж, харин МАН-д төвийн болон баруун аймгууд саналаа өгсөн байв. Ерөнхийдөө АН-ын хувьд анхан шатны санал хураалттай харьцуулбал нэг ч дүүрэг, аймгийг алдаагүйн сацуу эхний шатны санал хураалтын үеэр МАХН болон МАН-д саналаа өгсөн хэд хэдэн газраас нэмж санал авсан байна.

Шинээр сонгогдсон ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол СЕХ-ноос сонгуулийн албан ёсны дүнг зарласнаас хойш хэдхэн цагийн дараа, мөн сонгуультай холбоотой өргөдөл, гомдол гарах хуулинд заасан албан ёсны хугацаа дуусаагүй байхад буюу 7-р сарын 10-нд болов.⁹² Ерөнхийлөгч мөн өдрөө албан ажлаа хүлээж авав. Сонгуулийн дараах орчин тайван үргэлжилж, сонгуультай холбоотой эмх замбараагүй байдал үүсээгүй бөгөөд санал хураалтын дүнг эсэргүүцсэн өргөдөл, гомдол гарсангүй.

⁹² СТХ-ийн 113.3-р зүйл нь сонгуулийн байгууллагын шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор нэхэмжлэл гаргана гэж заажээ.

ХИХ. ЗӨВЛӨМЖ

Энэхүү тайланд дурдсан зөвлөмжүүдийг цаашид Монгол Улсад явуулах сонгуулийн үйл ажиллагааг сайжруулах, сонгуулийг ЕАБХАБ-ын болон олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд, ардчилсан сонгуультай холбоотой бусад хэм хэмжээтэй нийцүүлэн гаргах хүчин чармайлтыг дэмжин туслах үүднээс санал болгож байна. Эдгээр зөвлөмжийг ЕАБХАБ/АИХЭГ-аас өгсөн өмнөх зөвлөмжүүдтэй, ялангуяа Монгол Улсын хувьд хараахан тусгаж аваагүй зөвлөмжүүдтэй хамт уншиж танилцах нь зүйтэй. ЕАБХАБ/АИХЭГ нь Монгол Улсын эрх бүхий байгууллагуудыг цаашид сонгуулийн үйл явцаа сайжруулах, мөн энэ болон өмнөх тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд нь туслахад бэлэн байна.⁹³

А. НЭН ТЭРГҮҮНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД

1. Сонгуулийн тухай хууль тогтоомжинд байгаа хоёрдмол утга агуулсан, хоорондоо зөрчилдөж буй зүйл заалтыг дахин хянан авч үзэж, ялангуяа ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтыг зохицуулсан нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй.
2. Сонгууль зохион байгуулах байгууллагын үйл ажиллагааг хардах хардлагыг бууруулахын тулд сонгуулийн хороодын доод шатны бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах шалгуурыг ил тод, тодорхой болгох нь зүйтэй.
3. СЕХ болон доод шатны сонгуулийн хороод нь сонгуулийн хороодын хуралдааныг тогтмол, нээлттэй ил тод зарчим баримтлан, олон нийтэд урьдчилан зарлан мэдээлж, хийж занших нь зүйтэй. Хурлаар хэлэлцсэн асуудал, хурлын тэмдэглэл болон гаргасан шийдвэрүүдийг нэн даруй олон нийтэд мэдээлж байх нь зохистой.
4. Хорих ял эдэлж буй этгээдийн санал өгөх эрхийг хязгаарлахдаа үйлдсэн гэмт хэргийн ангиллаас хамааран хязгаарлах нь зүйтэй. Мөн олон улсын өмнө хүлээсэн үүрэгт нийцүүлэн эрх зүйн чадамжгүй гэх сэтгэцийн болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх эрхийг нь хязгаарласан заалтыг эргэн харж, санал өгөх эрхээ эдлэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлэх механизмыг бие болгох нь зүйтэй.
5. Бие даан нэр дэвшихийг зөвшөөрдөггүй болон УИХ-д суудалгүй нам нэр дэвшүүлэх эрхгүй гэх мэт сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлаж байгаа зохимжгүй хязгаарлалтуудыг өөрчлөх нь зүйтэй. Мөн эх орондоо байнга оршин суусан байх шаардлагыг эргэж харах нь зохистой.
6. Сонгуулийн сурталчилгаа дуусгавар болохоос өмнө сонгуулийн сурталчилгааны орлого, зарлагын төсөөллийг ил болгож, цахим хэлбэрээр олон нийтэд мэдээлэх шаардлагыг нэр дэвшигчид болон улс төрийн намуудад тавихыг холбогдох эрх бүхий байгууллагууд санаачлах нь зүйтэй.
7. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээний агуулга, санал асуулга нийтлэх, төлбөртэй нэвтрүүлгийн тухай заалтуудыг болон редакцийн агуулга, улс төрийн сурталчилгааны хоорондын зааг ялгааг тодорхой болгох нэмэлт өөрчлөлтийг СТХ-нд оруулах нь зүйтэй.
8. Нэмэлт санал хураалттай холбоотой хууль эрх зүйн болон зохион байгуулалтын асуудал гарах магадлал өндөртэйг харгалзан дээрх зохицуулалтыг бүхэлд нь халах нь зүйтэй. Үргэлжлүүлэн хэрэгжүүлэх аваас СТХ-ийн нэмэлт санал хураалтын тухай зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, тэгш сонгох эрхийг баталгаажуулах нь зохистой.

⁹³ ЕАБХАБ-ын 1999 оны Истанбулын Баримт бичгийн 25 дахь хэсэгт ЕАБХАБ-ын гишүүн орнууд нь “АИХЭГ-ын гаргасан сонгуулийн үнэлгээ, зөвлөмжүүдийг шуурхай мөрдөх” үүрэг хүлээнэ гэжээ.

9. Сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх хугацааг үндэслэлтэй болгож, сонгуулийн хуанлитай уялдуулах нь зүйтэй.

В. БУСАД ЗӨВЛӨМЖҮҮД

Хууль эрх зүйн орчин

10. Сонгуулийн байгууллагын тогтолцооны уялдаа холбоог баталгаажуулах, мөн хууль тогтоомжийг тууштай хэрэгжүүлэхэд сонгуулийн хууль тогтоомжид тодотгон нэмэх шаардлагатай гэж үзсэн зохицуулалт (дүрэм, журам)-ыг батлах бүрэн эрхийг СЕХ-нд олгохоор холбогдох хуулийг дахин хянан авч үзэх нь зүйтэй. Дээд шүүх нь Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ эргэн хэрэгжүүлж, СЕХ-ны хүсэлтээр холбогдох хууль тогтоомжийн талаар албан ёсны тайлбарыг гаргах нь зүйтэй.

Сонгуулийн тогтолцоо

11. Нэмэлт санал хураалттай холбоотой хууль эрх зүйн болон зохион байгуулалтын асуудал гарах магадлал өндөртэйг харгалзан дээрх зохицуулалтыг бүхэлд нь халах нь зүйтэй. Үргэлжлүүлэн хэрэгжүүлэх аваас СТХ-ийн нэмэлт санал хураалтын тухай зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, тэгш сонгох эрхийг баталгаажуулах нь зохистой.

Сонгуулийн байгууллага

12. СЕХ-ны зүгээс сонгуулийн шинэ техник технологийг ашиглах болон сонгуулийн дүрэм, журмыг тайлбарлаж, олон нийтэд ойлгуулах зэрэг сонгогчдод нэмэлт мэдээлэл олгох ажлууд хийх нь зүйтэй.
13. Санал өгөх цахим системд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд төхөөрөмжийн программын эх кодыг гуравдагч этгээдээр хараат бус баталгаажуулалт хийлгэх нь зүйтэй. Ийнхүү хийсэн хараат бус шалгалтын дүнг олон нийтэд нээлттэй байлгах нь зохистой.

Сонгогчийн бүртгэл

14. Сонгогчдыг нэрийн жагсаалтыг үйлдэхэд хэрэглэж буй технологийн хүчин чадлыг харгалзан сонгогчдын шилжилт хөдөлгөөн хийх үйл явцыг хялбаршуулах боломжтой. Сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг аймаг дотор хийхийг хориглосон заалт нь ерөнхийлөгчийн сонгуульд бодит ач холбогдолгүй тул эргэн харах нь зүйтэй.
15. Сонгогчийн бүртгэлийн явцад итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор сонгогчийн нэрийн жагсалтад хараат бус шалгалтыг иргэний нийгмийн байгууллага, эсвэл хараат бус гуравдагч байгууллагаар хийлгэж, шалгалтын дүнг олон нийтэд мэдээлэх нь зүйтэй.

Нэр дэвшигчийн бүртгэл

16. Сонгуульд нэр дэвшигчийг нэр дэвшүүлэх хугацааг сунгаж, сонгуулийн хуанлид эрт оруулах зохицуулалтыг хийж, нэр дэвшигчийг бүртгэх, зохих шалгалтыг хийх болон давж заалдах хангалттай хугацааг бүрдүүлж өгөх нь зүйтэй.

Сонгуулийн сурталчилгааны орчин

17. Сонгуулийн нэг ба хоёр дахь шатны санал хураалтын хооронд сонгуулийн сурталчилгаа явуулах хугацааг зөвшөөрөх талаар бодолцох нь зүйтэй.

18. Төрийн албан хаагчид сонгуулийн сурталчилгаанд оролцохыг хязгаарлах зүйл заалтыг холбогдох хууль тогтоомжид тодорхой оруулах нь зүйтэй. Үүний сацуу эдгээрийн хэрэгжилтийг хангах механизмыг мөн тогтоох нь зохиостой.
19. Сонгуулийн сурталчилгааны хугацаанд засгийн газрын зүгээс улсын төсөвт ихээхэн дарамт учруулах шинэ хөтөлбөр, санаачилгыг батлахаас зайлсхийх нь зомижтой.

Сонгуулийн сурталчилгааны зардал

20. Ил тод байдлыг нэмэгдүүлж, олон нийтэд судалж, нягтлах болон гомдол гаргах хангалттай цаг хугацаа олгох үүднээс нэр дэвшигчдийн хөрөнгө орлого болон татварын мэдүүлгийг олон нийтэд эртнээс зарлах нь зүйтэй.
21. Сонгуулийн сурталчилгааны дундуур болон дараах хугацаанд сонгуулийн сурталчилгааны зардлын зарцуулалтад үр дүнтэй хяналт тавих арга хэрэгслүүдийг ҮАГ-т олгох нь зүйтэй. ҮАГ-ын хийсэн аудитын урьдчилсан болон эцсийн тайлангуудыг олон нийтэд нийтэлж, тэр дундаа цахим хэлбэрээр мэдээлэх нь зохимжтой.

Хэвлэл мэдээлэл

22. Хэвлэл мэдээллийг зохицуулагч байгууллага нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эздийг тодорхой тогтоож, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгч эздийг нь олон нийтэд бүрэн ил тод болгох арга хэмжээг авах нь зүйтэй.
23. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн санхүүгийн бие даасан болон тогтвортой байдлыг хамгаалсан хууль эрх зүйн хамгаалалтыг бий болгож, хараат бус байдлыг хангаж, хэрэгжүүлэх нь зүйтэй.
24. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянах байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хамгаалахын тулд ХХЗХ-ны гишүүдийг томилж, чөлөөлөх журмыг эргэн харах нь зүйтэй.
25. Онлайн хэвлэлийн эрх чөлөөг хэтэрхий хязгаарлаж болзошгүй хуулийн зүйл заалтуудыг, мөн оногдуулж буй торгуулийн хэмжээ зэргийг эргэн харах нь зүйтэй.
26. Хэвлэл мэдээлэлтэй холбоотой бүх зохицуулалтыг хэрхэн дагаж мөрдөж байгаад хяналт тавих, хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх үүрэг бүхий бие даасан хяналтын нэг төвлөрсөн байгууллагатай байх нь зүйтэй. Үүргээ үр дүнтэй биелүүлэхэд нь шаардлагатай хүний болон техникийн нөөц бололцоогоор энэхүү байгууллагыг хангах нь нэн чухал.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо

27. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд ижил тэгш оролцох эрхийг хангахын тулд санал авах байруудад тэргэнцэртэй сонгогчид орох нөхцөлийг сайжруулахад СЕХ цаашид анхаарах нь зүйтэй.

Сонгуулийн өдөр

28. Олон нийтэд өгч буй мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд СЕХ нь цаашид сонгуулийн өдөр ирцийн тухай болон санал хураалтын өдрийн урьдчилсан бүрэн дүнг хэсгийн хороодоор задаргаа хийж зарлах нь зүйтэй.

ХАВСРАЛТ I – Сонгуулийн дүн

Анхан шатны санал хураалтын дүн – 6-р сарын 26-ны өдөр

Аймаг, дургийн сонгуулийн хороо	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Санал өгсөн сонгогчийн тоо	Ирц (хувь)	МАН-ын нэр дэвшигчийн төлөө өгсөн санал		АН-ын нэр дэвшигчийн төлөө өгсөн санал		МАХН-ын нэр дэвшигчийн төлөө өгсөн санал		Хоосон саналын хуудасны тоо	
				тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Архангай	59,599	39,922	66.98	12,059	30.21	12,398	31.06	14,932	37.40	533	1.34
Баян-Өлгий	58,882	39,255	66.67	19,332	49.25	14,218	36.22	5,205	13.26	500	1.27
Баянхонгор	54,214	39,925	73.64	11,497	28.80	23,886	59.83	4,137	10.36	405	1.01
Булган	39,948	26,939	67.44	7,782	28.89	8,585	31.87	10,263	38.10	309	1.15
Дархан-Уул	65,079	41,945	64.45	12,565	29.96	12,427	29.63	16,351	38.98	602	1.44
Дорнод	50,197	30,738	61.23	8,092	26.33	10,288	33.47	11,914	38.76	444	1.44
Дорноговь	42,892	28,718	66.95	9,535	33.20	9,206	32.06	9,635	33.55	342	1.19
Дундговь	29,281	19,771	67.52	5,142	26.01	5,414	27.38	9,004	45.54	211	1.07
Говь-Алтай	35,985	24,432	67.89	9,592	39.26	6,565	26.87	8,101	33.16	174	0.71
Говь-Сүмбэр	10,410	7,076	67.97	2,031	28.70	2,414	34.12	2,557	36.14	74	1.05
Хэнтий	47,331	31,670	66.91	7,804	24.64	11,253	35.53	12,162	38.40	451	1.42
Ховд	51,593	34,352	66.58	13,724	39.95	10,060	29.29	10,221	29.75	347	1.01
Хөвсгөл	83,007	54,978	66.23	18,896	34.37	17,488	31.81	17,863	32.49	731	1.33
Орхон	66,893	43,570	65.13	9,863	22.64	14,771	33.90	18,451	42.35	485	1.11
Сэлэнгэ	69,976	46,690	66.72	15,619	33.45	14,844	31.79	15,519	33.24	708	1.52
Сүхбаатар	39,223	28,133	71.73	10,023	35.63	9,320	33.13	8,411	29.90	379	1.35
Төв	61,158	41,181	67.34	16,546	40.18	11,253	27.33	12,855	31.22	527	1.28
Өмнөговь	41,816	27,025	64.63	7,238	26.78	8,087	29.92	11,484	42.49	216	0.80
Увс	49,386	34,050	68.95	16,698	49.04	10,355	30.41	6,703	19.69	294	0.86
Өвөрхангай	72,786	47,037	64.62	17,908	38.07	14,624	31.09	13,883	29.52	622	1.32
Завхан	45,279	31,524	69.62	12,505	39.67	12,022	38.14	6,726	21.34	271	0.86
Улаанбаатар	906,747	634,090	69.93	166,302	26.23	275,021	43.37	182,782	28.83	9,985	1.57
Гадаад дахь сонгогч	7,209	4,767	66.13	995	20.87	2,979	62.49	740	15.52	53	1.11
Нэгдсэн дүн	1,988,891	1,357,788	68.27	411,748	30.32	517,478	38.11	409,899	30.19	18,663	1.37

Хоёр дах санал хураалтын дүн – 7 дугаар сарын 7-ны өдөр

Аймаг, дүүргийн сонгуулийн хороо	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Санал өгсөн сонгогчийн тоо	Ирц (хувь)	МАН-ын нэр дэвшигчийн төлөө өгсөн санал		АН-ын нэр дэвшигчийн төлөө өгсөн санал		Хоосон саналын хуудасны тоо	
				тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Архангай	59,648	35,340	59.25	15,519	26.02	16,763	47.43	3,058	8.65
Баян-Өлгий	58,991	38,470	65.21	21,306	36.12	16,201	42.11	963	2.50
Баянхонгор	54,271	35,705	65.79	11,944	22.01	23,085	64.65	676	1.89
Булган	39,978	23,159	57.93	9,360	23.41	11,568	49.95	2,231	9.63
Дархан-Уул	65,126	36,227	55.63	16,154	24.80	16,496	45.54	3,577	9.87
Дорнод	50,225	26,273	52.31	10,271	20.45	13,535	51.52	2,467	9.39
Дорноговь	42,932	25,987	60.53	12,456	29.01	11,657	44.86	1,874	7.21
Дундговь	29,314	17,382	59.30	8,243	28.12	6,420	36.93	2,719	15.64
Говь-Алтай	36,014	20,575	57.13	10,793	29.97	8,334	40.51	1,448	7.04
Говь-Сүмбэр	10,413	6,561	63.01	3,331	31.99	2,764	42.13	466	7.10
Хэнтий	47,357	26,889	56.78	9,658	20.39	14,452	53.75	2,779	10.34
Ховд	51,638	29,783	57.68	14,451	27.99	13,135	44.10	2,197	7.38
Хөвсгөл	83,054	49,058	59.07	21,550	25.95	24,135	49.20	3,373	6.88
Орхон	66,947	37,266	55.66	12,452	18.60	20,042	53.78	4,772	12.81
Сэлэнгэ	70,035	41,626	59.44	20,032	28.60	18,381	44.16	3,213	7.72
Сүхбаатар	39,243	23,969	61.08	10,860	27.67	11,628	48.51	1,481	6.18
Төв	61,214	36,206	59.15	19,192	31.35	14,562	40.22	2,452	6.77
Өмнөговь	41,845	21,308	50.92	8,412	20.10	10,258	48.14	2,638	12.38
Увс	49,439	31,027	62.76	17,367	35.13	12,172	39.23	1,488	4.80
Өвөрхангай	72,817	41,700	57.27	20,209	27.75	19,001	45.57	2,490	5.97
Завхан	45,313	29,869	65.92	13,993	30.88	14,632	48.99	1,244	4.16
Улаанбаатар	907,774	570,731	62.87	209,017	23.03	309,975	54.31	51,739	9.07
Гадаад дахь сонгогч	7,209	2,676	37.12	497	6.89	2,030	75.86	149	5.57
Нэгдсэн дүн	1,990,797	1,207,787	60.67	497,067	24.97	611,226	50.61	99,494	8.24

ХАВСРАЛТ II – Олон улсын сонгуулийг ажиглах хорооны ажиглагчдын нэрийн жагсаалт**ЕАБХАБ-ын Парламентын Ассамблей**

Нэр	Овог	Улс	Албан тушаал
GUGLIELMO	PICCHI	Итали	Тусгай зохицуулагч
GEORGIOS	VAREMENOS	Грек	Төлөөлөгчдийн тэргүүн
ANTON	HEINZL	Австри	Парламентын гишүүн
ROMAN	HAIDER	Австри	Парламентын гишүүн
ANNE-MARIE	MAES	Бельги	Парламентын гишүүн
BORIS	YACHEV	Болгар	Парламентын гишүүн
DESLAVA	ATANASOVA	Болгар	Парламентын гишүүн
LADISLAV	VACLAVEK	БНЧех Улс	Парламентын гишүүн
RASMUS	JARLOV	Дани	Парламентын гишүүн
EGON	JUTTNER	ХБНГУ	Парламентын гишүүн
LISA	CHAMBERS	Ирланд	Парламентын гишүүн
FRANCESCO			Парламентын гишүүн
CARMELO MARIA	SCALIA	Итали	Парламентын гишүүн
CLAUDIO	FAVA	Итали	Парламентын гишүүн
JAN	LOPATA	Польш	Парламентын гишүүн
SLAWOMIR	NITRAS	Польш	Парламентын гишүүн
CELIL	GOCER	Турк	Парламентын гишүүн
HATICE	ER AS	Турк	Парламентын гишүүн
KATERINA	KOSARIKOVA	БН Чех Улс	Төлөөлөгчдийн нарийн бичиг
THALIA	PAPADOPOULOU	Грек	Төлөөлөгчдийн нарийн бичиг
ULVI	ALIZADA	Азербайжан	ЕАБХАБ-ын ПА-н ТГ
ANDREAS	BAKER	Канад	ЕАБХАБ-ын ПА-н ТГ
IRYNA	SABASHUK	Украин	ЕАБХАБ-ын ПА-н ТГ

Европын Парламент

Нэр	Овог	Улс	Албан тушаал
LAIMA LIUCIJA	ANDRIKIENĖ	Литва	Төлөөлөгчдийн тэргүүн
JOACHIM	ZELLER	ХБНГУ	Парламентын гишүүн
IVAN	STEFANEC	Словак	Парламентын гишүүн
ENRIQUE	GUERRERO SALOM	Испани	Парламентын гишүүн
JAVIER	NART	Испани	Парламентын гишүүн
GABRIELA	VIROSTKOVA	Словак	Улс төрийн бүлгүүд
PHILLIPE	KAMARIS	Франц	ЕП-ын Нарийн бичгийн дарга нарын газар
CRISTINA	CASTAGNOLI	Итали	ЕП-ын Нарийн бичгийн дарга нарын газар
DANIELA	RECINELLA	Итали	ЕП-ын Нарийн бичгийн дарга нарын газар

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны Үндсэн баг

Нэр	Овог	Улс	
GEERT-HINRICH	AHRENS	ХБНГУ	Хорооны тэргүүн
ANNA	PAPIKYAN	Армени	
MARIANNA	SKOPA	Грек	

Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26 болон 7-р сарын 7-ны өдрүүд
 ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны Тайлан

AHMAD	RASULI	БН Киргиз Улс
INTA	LASE	Латви
TOMASZ	JANCZY	Польш
ROMAN	RAILEAN	Румын
SERGEY	RADCHENKO	ОХУ
JELENA	STEFANOVIĆ	Серби
EGOR	TILPUNOV	Украин
GAVIN	WEISE	ИБУИНВУ
NOAH	LANE	АНУ

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны урт хугацааны ажиглагчид

Нэр	Овог	Улс
HRIPSIME	GRIGORYAN	Армени
DENISE DORIS	WAPPEL	Австри
TOMAS	TRAMPOTA	БН Чех Улс
KATERINA	DUFFKOVA	БН Чех Улс
KIRSTEN PIA	MOGENSEN	Дани
ADELINÉ	MARQUIS	Франц
LAURENT	CAMPIGOTTO	Франц
PETRA MARIA	BORNHOEFT	ХБНГУ
CAROLA	KASBURG	ХБНГУ
SILKE GISELA	TITTEL	ХБНГУ
PETER JOHN	EMERSON	Ирланд
EVA-KRISTIN	PEDERSEN	Норвеги
CECILIE GULBRAAR	ORESTIS	Норвеги
CRISTIAN-DANIEL	BESLIU	Румын
YURI	SHAPOVALOV	ОХУ
ELIZAVETA	BORISOVA	ОХУ
KONSTANTIN	STOLIAROV	ОХУ
VIDA	KOREN HOLM	Швед
	ROGALSKA	
ANNA	HEDLUND	Швед
ALEXANDER	KASHUBIN	Узбекистан

ЕАБХАБ-ЫН АИХЭГ-ЫН ТУХАЙ

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын үндсэн институт болох Ардчилсан институт, хүний эрхийн газар (ЕАБХАБ-ын АИХЭГ) нь тус байгууллагын оролцогч орнуудад “хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн хүндэтгэсэн байдлыг хангах, хууль дээдлэх ёсыг сахих, ардчиллын зарчмыг болон (...) хөхүүлэн дэмжих, ардчилсан институциудыг байгуулах, бэхжүүлэх, хамгаалах, түүнчлэн нийгмийг бүхэлдээ харилцан хүндэтгэлтэй хандах хандлагыг хөхүүлэн дэмжих”-д туслалцаа үзүүлэх зорилготой (1992 оны Хельсинкийн Дээд хэмжээний уулзалтын баримт бичиг). Үүнийг ЕАБХАБ-ын хүний хэмжигдэхүүн гэж үздэг байна.

Польш Улсын Варшав хотод байрладаг ЕАБХАБ-ын АИХЭГ нь 1990 оны Парисын Дээд хэмжээний уулзалтын үеэр Чөлөөт сонгуулийн төлөө газар нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 1991 оны 5-р сараас үйл ажиллагаагаа эхэлжээ. Тус байгууллагын эрх нь хүний эрх, ардчилалтай холбоотой асуудлаар өргөжсөн тул жилийн дараа уг байгууллагын нэрийг өөрчилсөн. Өнөөдөр тус байгууллага нь 150 гаруй ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь **сонгуулийн ажиглалт явуулах** чиглэлээр Европод тэргүүлдэг байгууллага юм. ЕАБХАБ-ын бүс нутагт явагдаж байгаа сонгуулиуд нь ЕАБХАБ-ын үүрэг амлалт, ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын бусад хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжийг даган мөрдөж байгаа эсэхэд үнэлгээ өгөх олон мянган ажиглагчдыг томилж, сонгуулийн ажиглалтыг жил бүр зохион байгуулдаг. Тус байгууллагын өвөрмөц аргачлал нь сонгуулийн үйл явцад бүрэн ажиглалт хийх боломж олгодог. ЕАБХАБ-ын АИХЭГ нь төрөл бүрийн төсөл, хөтөлбөрөөр дамжуулан сонгуулийн хууль эрх зүйн тогтолцоог сайжруулахад нь оролцогч орнуудад туслалцаа дэмжлэг үзүүлдэг.

ЕАБХАБ-ын **ардчиллын үйл явцыг дэмжих** үйл ажиллагаанд хууль дээдлэх ёс, хууль эрх зүйн дэмжлэг, ардчилсан засаглал, шилжилт хөдөлгөөн, шилжин суух эрх чөлөө, жендэрийн тэгш байдал багтана. ЕАБХАБ-ын АИХЭГ нь ардчилсан засаглалыг хөгжүүлэхийг эрэлхийлэн, жил бүр зорилтот төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь түүнчлэн **хүний эрх**, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүргээ ЕАБХАБ-ын хүний хэмжигдэхүүний үүрэг амлалтад нийцүүлэн биелүүлэхэд нь оролцогч орнуудад тусалдаг. Ингэхийн тулд бусад түнш байгууллагуудтай хамтран терроризмтэй тэмцэх явцад хөндөгдөх хүний эрх, хүний наймааны гэмт хэргийн хохирогчдын эрхийн хамгаалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр сэдэвчилсэн хэлэлцүүлгүүд зохион байгуулахын сацуу хүний эрхийн боловсрол, сургалт, хүний эрхийн мониторинг хийж, тайлан гаргах болон эмэгтэйчүүдийн эрх, аюулгүй байдлын талаарх чадавхыг бэхжүүлэх, мэдлэг туршлагаа харилцан хуваалцдаг.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь **бусдад хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлан гадуурхах** чиглэлийн хүрээнд бусдыг үзэн ядах гэмт хэрэг, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн зөрчил, гадаад иргэдийг үзэн ядах үзэл, семитийн эсрэг үзэл болон бусад хэлбэрийн үл хүндэтгэсэн үйлдэлд хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэхэд оролцогч орнууддаа тусалдаг. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын бусдад хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлан гадуурхахтай холбоотой үйл ажиллагаа нь дараах асуудалд чиглэнэ. Үүнд хууль тогтоомж; хууль хэрэгжүүлэх тухай сургалт; үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх арга хэмжээг хянах, тайлагнах, нягтлах; түүнчлэн бусдад хүндэтгэлтэй хандах, хүндэтгэх болон хамтын ойлголцлыг хөхиүлэн дэмжсэн боловсролын арга хэмжээ зэрэг багтана.

Түүнчлэн тус газар нь **Рома, Синтигийн** (Roma and Sinti) асуудлаар баримтлах бодлогод оролцогч гишүүн орнуудад зөвлөгөө өгдөг. Мөн тэднийг нийгэмшүүлэх, чадавхжуулах, сүлжээ үүсгэх асуудлыг хөхиүлэн дэмжихийн зэрэгцээ бодлого боловсруулах түвшинд тэдний төлөөллийг оруулцуулахыг дэмждэг.

АИХЭГ нь ЕАБХАБ-ын оролцогч гишүүн орнууд, ЕАБХАБ-ын бусад институци болон олон улсын бусад байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулж, харилцан хамтран ажиллаж, хэрэгжүүлдэг.

Дэлгэрэнгүй мэдээлэлтэй АИХЭГ-ын (www.osce.org/odihr) цахим хуудаснаас танилцана уу.